

ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5–9 Зохицуулалтын мэдээ
- 10–11 Ярилцлага
- 12 Тогтвортой санхүүжилт
- 13 Компанийн засаглал, комплайнс
- 14–15 Финтек ба регтек
- 16–23 Судлаачийн индэр
- 24–25 Үл хөдлөх эд хөрөнгийн хөрөнгө оруулалтын сан гэж юу вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ШИЛЖИЛТИЙН БОНД

Санхүүгийн зах зээлд бондын олон төрлүүд тухайлбал, байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зориулалтаар хөгжиж байна. Үүнд (i) Байгаль орчин, тогтвортой хөгжлийн төсөлд анхаарал хандуулсан "Ногоон Бондууд", (ii) Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд зориулагдсан "Нийгмийн Бондууд", (iii) Эдгээр хоёрын уулзвар болох "Тогтвортой Бондууд", мөн (iv) "Тогтвортой байдалтай Холбогдох Бондууд" гэсэн шинэлэг хэлбэрүүд орж байна. Тодорхойлолт нь төдийлөн танигдаагүй ч, зарим хувийн салбарын оролцогчид байгаль орчинд өндөр бохирдол үүсгэдэг, нүүрс төрөгч ялгаруулдаг үйл ажиллагаанаас байгаль орчинд ээлтэй, ногоон үйл ажиллагаанд шилжиж буйгаа илэрхийлэхийн тулд "Шилжилтийн Бонд"-ийг гаргаж эхэлжээ. Эдгээр арга хэрэгсэл нь тогтвортой, ногоон ирээдүйг бий болгох үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

ШИЛЖИЛТИЙН БОНД ГЭЖ ЮУ ВЭ?

Шилжилтийн бонд /transition bond/ гэдэг нь ногоон бондын шаардлага хангаагүй нүүрсхүчлийн хий ихээр ялгаруулдаг компаниудад, ялангуяа "хүрэн" үйлдвэрүүдэд (ган, цемент, нефть химийн үйлдвэрлэл зэрэг өндөр хий ялгаруулдаг салбарууд) зориулж нүүрсхүчлийн хийн ялгаруулалтаа бууруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нь багасгахад зориулсан төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашигладаг өрийн хэрэгслийн нэг төрөл юм.

Тогтвортой бондын зах зээлд голлох байр суурь эзэлдэг ногоон бонд нь байгаль орчинд ээлтэй шинэ бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд өөрөөр хэлбэл "ногоон" шинж чанартай төсөл санхүүжүүлэхэд төвлөрдөг бол шилжилтийн бонд нь компанийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах эсвэл нүүрсхүчлийн ялгарал багасгах шилжилтийг санхүүжүүлэх тал руу төвлөрдөг.

Харин Уур амьсгалын шилжилтийн бондтой байгаль орчинд нөлөөлөх, нүүрсхүчлийн хий ялгаруулалтыг багасгахад туслах төслүүдийг санхүүжүүлэхээрээ ижил төстэй боловч уур амьсгалын бонд голчлон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхтэй холбоотой шилжилт рүү чиглэдэг бол шилжилтийн бонд том хүрээтэй ойлголт бөгөөд компанийн тогтвортой байдал руу шилжихийн тулд ашиглагддаг.




ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Жендерийн тэгш байдал

Gender equality

Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын болон гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулах алсын харааг хэлнэ. Жендерийн тэгш байдал нь НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэг зорилт юм.



Жижиг, дунд бизнес эрхлэгч

SME entrepreneur

Ажиллагчдын тоо, жилийн борлуулалтын хэмжээ зэргийг харгалзан улс орон бүр ялгаатай тодорхойлдог. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд Монгол Улсын ЖДҮ эрхлэгч нь иргэн, ААН байх бөгөөд үйл ажиллагаанаас хамааруулан тодорхойлсон байдаг.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД САНХҮҮГИЙН ДЭМЖИГЧ БОЛОХ НЬ

УКРАИНЫ ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (2016–2024)

Өртөг багатай санхүүжилт бүхий л төрлийн бизнес, үйл ажиллагааны хөдөлгөгч хүч нь байдаг. Гэвч Украины бичил, жижиг, дунд хэмжээний хөдөө аж ахуй эрхлэгчдэд энэ төрлийн санхүүжилт олддоггүй хүндрэлтэй байсан. Хөдөө аж ахуй эрхлэгчдийн хэрэгцээ харьцангуй жижиг учраас банк тоодоггүй, зээл олгодоггүй. Энэхүү орон зайг хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх)–д тэдэнд зориулсан бүтээгдэхүүнээрээ нөхөж ажиллах боломжтой боловч ХЗХ–ны салбарт реформын шинэчлэл 25 жилийн хугацаанд хийгдээгүйгээс ХЗХ–доо чадавхжуулах, гишүүдийнхээ хэрэгцээнд нийцсэн санхүүгийн байгууллага болгох боломжгүй байсан.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (WOCCU), Америкийн хамтын ажиллагааны хөгжлийн агентлаг (USAID)–тай хамтран Украины хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийг дэмжих төсөл (Credit for Agricultural Producers Project)–ийг 2016–2020 онд хэрэгжүүлж, улмаар төслийн хугацааг сунгаж 2020–2024 онд үргэлжлүүлсэн.

Төслийн 2 дахь шатанд буюу 2022 оны 02 дугаар сард Орос–Украины дайн гарсан тул ХЗХ–д үндэсний холбоо болон зохицуулагч байгууллагатайгаа хамтран ажиллаж, орон нутаг дахь хүнсний аюулгүй байдал болон гишүүдийн бусад хувийн хэрэгцээг хангах зориулалттай зээлийг олгож зах зээлийн хэрэгцээг хангахад хувь нэмрээ оруулсан.

Энэхүү төслийн зорилго нь хөдөө аж ахуйн бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч болон тариаланчдад хөдөө аж ахуйн зориулалтын зээл олгох ХЗХ–дыг чадавхжуулах бөгөөд дараах 4 бүлэг ажлыг хийсэн. Үүнд:

Хэрэгцээг хангаж чадахгүй болсон Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, эрх зүйн зохицуулалтыг Украины зохицуулагч болон хууль тогтоогч байгууллагатай хамтран олон улсын болон Европын холбооны шилдэг туршлагад нийцүүлэн шинэчилж, хөдөө аж ахуйн болон эдийн засгийн өсөлтийг дэмжих урт хугацааны сан үүсгэх замаар зээл олгохыг дэмжих;

Гишүүдийн хэрэгцээнд нийцсэн дижитал шилжилтийг дэмжихийн зэрэгцээ кибер аюулгүй байдлыг сайжруулах;

ХЗХ–оор олгох хөдөө аж ахуйн болон бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

Орон нутаг болон хөдөө аж ахуйн бичил, жижиг бизнес, түүн дотроо эмэгтэй удирдлагатай, орон нутагт шилжсэн эсхүл нутагтаа эргэн очсон бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх зээлийг олгох ХЗХ–дыг чадавхжуулах.

2023 оны 12 дугаар сарын байдлаар төслийн хамтрагч ХЗХ–доор 26 сая ам.доллартой тэнцэх хэмжээний 20,000 хөдөө аж ахуйн зориулалттай зээлийг олгосноос 4,000 зээлийг дайны үед олгосон байна.

ГУАТЕМАЛ, СЕНЕГАЛ, БУРКИНА ФАСО, КЕНИ УЛСЫН ХОРШООДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР: САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИД ТЕХНОЛОГИ БА ИННОВАЦ (CDP TIFI) (2018–2024)

ХЗХ–д хадгаламж, зээл, даатгал зэрэг иргэдийн хэрэгцээний санхүүгийн үйлчилгээг хүргэдэг боловч жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биелэгдэшгүй санхүүгийн хэрэгцээ их байдаг нь хөгжиж буй орнуудад ажиглагддаг. Энэ нь ХЗХ–д жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зориулсан зээлийг гаргах боломж хомс, нөгөө талаар арга нь тодорхойгүй байдагтай холбоотой. Дэлхийн банкны Global Findex судалгаагаар дэлхийн хэмжээнд насанд хүрэгчдийн 11 хувь, АНУ–ын хүн амын 34 хувь зээл авах боломжтой байдаг бол хөтөлбөрт хамрагдсан орнуудын хувьд энэ үзүүлэлт 6–8 хувь байна. Эмэгтэйчүүд, залуучууд, орон нутгийн иргэдийн зээл авах боломж нь дунджаас ч бага үзүүлэлттэй байдаг.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (WOCCU) Америкийн хамтын ажиллагааны хөгжлийн агентлаг (USAID) –тай хамтран жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Буркина Фасо, Гуатемал, Кени улсад тухайн улс бүрийн ХЗХ–дын төв хоршоо буюу нэгдсэн төвөөр нь дамжуулан хөтөлбөр хэрэгжүүлж, 2020 онд Сенегал улсыг хамруулж үйл ажиллагааг тэлсэн. Эдгээр 4 улсын ХЗХ–дын төв хоршоо буюу нэгдсэн төв нь салбарын сая сая гишүүдийн сүлжээг төлөөлж техникийн туслалцаа үзүүлж ажилласан.

Энэ хүрээнд дараах ажлуудад анхаарсан:

Жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зээл олгох ХЗХ–дод ирэх эрсдэлийг багасгах (жижиг, дунд үйлдвэрлэгч нар бичиг баримтын болон барьцаа хөрөнгийн шаардлагыг хангадаггүй, өмнө авсан зээлийн түүхгүйгээс уламжлалт тогтолцоогоор зээл авахад хүндрэлтэй байдгийг харгалзсан);

Жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зээл олгох ажиллагааг

хялбаршуулж, зээлийн өртгийг бууруулах;

Жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зориулсан санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн тоог олшруулах замаар жижиг, дунд үйлдвэрлэгч нарыг санхүүгийн хүртээмжтэй болгох.

Зорилтот 4 улсын ХЗХ–дод хэрэгжүүлсэн хөтөлбөрөөс амжилттай бойжсон жижиг, дунд үйлдвэрлэгч нарын жишээнээс дурдъя.

АМЖИЛТЫН ТҮҮХ 1: САНХҮҮГИЙН ХОРШОО ХОСУУДЫН БИЗНЕСИЙГ ЦЭЦЭГЛҮҮЛЭХЭД ТУСАЛЖЭЭ

2023 оны 05 дугаар сар: 40 настай Вик Туртон үргэлж өөрийн гэсэн бизнестэй болохыг мөрөөддөг байсны эцэст 2019 онд том өөрчлөлтийг хийж чадсан. Олон жилийн турш Гватемал дахь томоохон шувууны аж ахуй, гахайн фермүүдэд нэмэлт тэжээл өгөх ажил хийж байсны дараа 39 настай эхнэр София Пиваралтай хамт Гватемалчуудын тэжээдэг амьтдыг өсгөхөд шаардлагатай орц найрлагыг хангасан орон нутгийн өмчит үйлчилгээгээ “Турпиласа” гэж нэрлэсэн. Харин Вик, София нар дэлхий нийтийг хамарсан цар тахал энэ бүхнийг өөрчилнө гэдгийг огт мэдээгүй.

Эмэгтэй удирдлага бүхий энэ бизнес 2019 оны 10 дугаар сард Гватемалын баруун зүгт байх Сан Хосе Пинула хотод нээгдэж, Вик, София 2 шувууны аж ахуйд ажиллах туршлагатай борлуулалт хариуцсан менежер ажилд авч, София өөрөө бизнесийн дотоод асуудлаа хариуцсан. Удалгүй том үйлчлүүлэгчид тэдний бизнесийг сонирхох болж, том корпорацуудын их хэмжээний худалдан авалтууд шинэ бизнес эрхлэгчдийн амжилтын баталгаа болсон. Тэр хэрээр олон хүн ажилд авах, мөн банктай зээлийн гэрээ хийж, зээлийн шугам нээх хэрэгцээ гарсан. Томоохон үйлчлүүлэгчид төлбөрөө 60 хоногийн дараа хийх нөхцөл тавьдаг бол “Турпиласа” өөрийн нийлүүлэгчдэд энэ болзлоор хэлэлцээ хийх боломжгүй нь санхүүжилтийн хомсдол үүсгэсэн. “Ковид–19” дэлхийн эдийн засгийг зогсонги байдалд оруулснаар банкнууд Вик, София хоёрт үйлчилгээ үзүүлээгүй. Тэднийг нотлох 3 жилийн санхүүгийн түүх байхгүйгээс санхүүжилт авч чадаагүй.

Дараа нь Софиягийн найз түүнд зохицуулалтын онцлогоос болж санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй бизнест туслах зорилготой “Кредипими” хэмээх хоршоонд суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн талаар ярьсан. Америкийн хамтын ажиллагааны хөгжлийн агентлаг (USAID) –ийн санхүүжилтээр Дэлхийн хадгаламж, зээлийн

хоршоодын холбоо (WOCCU)–оос хэрэгжүүлэх техникийн дэмжлэг болон чадавхыг бэхжүүлж хоршоодыг дэмжих хөтөлбөр (CDP)–т Гватемалын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (FENACOAC) 23 ХЗХ–той хамтран “Кредипими”–г байгуулж, 5.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. “Кредипими” нь банкууд шиг санхүүгийн баталгаа, санхүүгийн түүх шаардахгүйгээр жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зээл олгож, улсдаа учирсан 18 тэрбумын санхүүгийн хомсдолыг нөхөхөд тусалсан. Энэ жишгээр “Турпиласа”–г үнэлж, боломжид нь тохируулан шаардлагатай санхүүжилтийг олгосон.

Үр дүнд нь Вик, София 2 цар тахлын улмаас уналтад орсон бизнесээ сэргээж, бусад асуудлууддаа санаа тавих боломжтой болсон. Өнөөдөр “Турпиласа” хосуудын мөрөөдлөөс 17 ажилтантай, цаашид ч өсөх ирээдүйтэй жижиг бизнес болж өргөжсөн байна. Одоо Вик, София 2 хүний хоол тэжээлийн шинэ бизнес дээр ажиллаж байна. Софигийн хэлснээр “Кредипими” нь найдвартай түнш байж, зээлийн шугамыг хэзээ нээх, хэзээ хаавал зүйтэй талаар зөвлөж, “Турпиласа”–гийн бизнес төлөвлөгөөг гаргахад ч тусалсан байна.

АМЖИЛТЫН ТҮҮХ 2: КЕНИ УЛСЫН ХЗХ–Д ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЗНЕС ЭРХЛЭХ МӨРӨӨДЛИЙГ БОДИТ БОЛГОЖЭЭ

2023 оны 06 дугаар сар: Нэнси Кариуки өөрийн гэсэн бизнестэй болохыг мөрөөддөг эм зүйч хүн. 8 жилийн турш эмийн компанид ажиллаж байгаад 40 насандаа нэг том алхам хийсэн. Эмэгтэйчүүд бизнес эрхлэхэд тулгардаг бэрхшээлүүдийг сайн мэддэг Нэнси олон жилийн турш мөнгө хадгалсан бөгөөд 2020 онд сая кеси (ойролцоогоор 7300 ам.доллар) буюу эхлэлийн хөрөнгөтэй болсон. Тэр өөрийн бизнес болох “Эссос фармаци” эмийн санг Кени

улсын төв хэсэгт орших 15,000 хүн амтай Керугоя хотын төв дүүрэгт нээсэн.

Нэнсигийн бизнес 2 жилийн турш маш амжилттай явсан бөгөөд 2022 онд цар тахлын улмаас эмийн эрэлт нэмэгдэж, түүнд санхүүжилт хэрэгтэй болсон тул “Фортуна” SACCO–той холбогдсон. SACCO буюу ХЗХ–д нь санхүүгийн үйлчилгээний нэг сонголт болдгоороо Кени улсад алдартай. SACCO–ийн гишүүд хоршоондоо хөрөнгө оруулах эсвэл хадгаламж байршуулж, зээл авахдаа түүнийгээ барьцаалж болдог. SACCO–оос авах зээл нь хэмжээний хувьд банкны олгохоос их, хүү нь бага байдаг.

“Фортуна” SACCO нь Нэнсигийн хамгийн их хүсэж байсан зүйлээ хийх, шинэ ажлын байр бий болгоход хангалттай хэмжээний зээлийг олгосон. Зөвхөн нөхөртөө найдаж тусламж авдаг байсан бол одоо 4 ажилтантай болсон байна. Мөн ажилчдаа Орон сууцны даатгалын үндэсний сан, Үндэсний нийгмийн хамгааллын санд бүртгүүлж, эрүүл мэнд, тэтгэвэр, нийгэм хамгааллаар хангасан.

Жилийн дотор бизнесийн орлогоо 3 дахин нэмэгдүүлж, одоо томоохон эмийн сангуудтай өрсөлддөг болсон. Түүний амжилт нь бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулаад зогсохгүй бусад бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд урам зориг өгч байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД АЖИЛЛАЛАА



УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай танилцлаа. Уулзалтын эхэнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц санхүүгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, салбаруудад хэрэгжүүлж буй бодлого зохицуулалт, онцлох ажлуудынхаа талаар товч мэдээлэл танилцуулав. Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, дотоодын аж ахуйн нэгжээс тус зах зээлээр дамжуулан урт хугацааны санхүүжилт татахад таатай зохицуулалтын орчныг бүрдүүлж, шинэ бүтээгдэхүүний тоог өсгөн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоог сайжруулах, хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг нөлөөг нэмэгдүүлэх хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжээс бирж болон биржийн бус зах зээлд нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд үнэт цаас гаргах ажиллагаанд тавигдах шалгуурыг багасгаж, хялбар шуурхай байдлаар бүртгэх эрх зүйн орчныг бүрдүүлээд байна. Мөн банк бус санхүүгийн салбарт хэрэглээний зээлийг бууруулах замаар зээлийн эх үүсвэрийг бизнесийн зээл рүү чиглүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийг өрөөр биш ажил эрхэлсэн орлогын өсөлтөөр хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжийг олгох зорилгоор ББСБ-уудын олгох хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаанд холбогдох зохицуулалт хийсэн. Цаашид, энэ салбарт валютын арилжааны нэгдсэн мэдээллийн сан бүхий платформ бий болгож, тайлан, мэдээг бодит цагийн горимоор авдаг тогтолцоог бүрдүүлэх, валютын арилжаатай холбоотой шалгуур үзүүлэлтийг нэмж тогтоох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагууд тавих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр

ажиллаж байгаа ба хуулийн шинэчлэлийн хүрээнд Тухайлбал, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд хуулийн шинэчлэлийн үр дүнд олон тулгуурт даатгалын тогтолцоог бүрдүүлэх, даатгалын хураамжийг дотооддоо авч үлдэх, давхар даатгалын хураамжийн тодорхой хувийг дотоодын давхар даатгагчид шилжүүлэх, томоохон эрсдэлийг хамтран даатгах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг давуу талтай. Мөн дотоодын давхар даатгалыг дэмжсэн зохицуулалтын орчин бий болж гадагш гарч буй валютын урсгалыг бууруулах, даатгалын компаниуд хөрөнгийн зах зээлд оролцох боломж нэмэгдэж томоохон, мэргэшсэн хөрөнгө оруулагч болж хөгжих боломж бүрдэнэ гэдгийг онцолсон юм.

Уулзалтын төгсгөлд УИХ-ын дарга Д.Амарбаясгалан



“Санхүүгийн салбарын хууль, эрх зүйн орчин харьцангуй сайн буюу бусад салбартай харьцуулахад түрүүлж алхаж чаддаг, эрх зүйн шинэчлэлийг цаг тухай бүрт нь хийж ирсэн салбар. Гэхдээ УИХ-аас тавьж буй шаардлага бол санхүүгийн системээ хамгаалах, баталгаатай орчныг бүрдүүлэхээс гадна иргэд, хэрэглэгчдийн эрхийг хангах, эрх тэгш байх мөн илүү хямд хүүтэй зээл авч санхүүгийн харилцаанд орох тэр боломж, нөхцөлийг бүрдүүлэх юм. Иргэдэд ээлтэй зээлийн орчныг бий болгох нь бидний өнөөдрийн уулзалтын гол үр дүн байх ёстой. Ийм учраас УИХ-ын даргын захирамжаар санхүүгийн салбарын хууль эрхзүйн орчны томоохон шинэчлэл хийх ажлын хэсгийг байгуулж энэ салбарын өргөн барихад бэлтгэгдсэн хуулийн төслүүдийг УИХ-д өргөн барьж хаврын чуулганаар амжиж хэлэлцэн батлахыг гол зорилгоо болгоно гэдгээ онцоллоо.

“БОНД ФОРУМ–2025” АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монгол Улсын Их Хурлын даргын санаачилгаар зохион



байгуулж буй “Бонд Форум–2025” арга хэмжээ Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/–д боллоо. Бондын зах зээлийн ач холбогдлыг сурталчлан иргэд, олон нийт болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг бонд гаргах замаар санхүүжилт татах сонирхлыг дэмжих зорилготой форумд УИХ–ын дарга Д.Амарбаясгалан, УИХ–ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж, УИХ–ын гишүүн Г.Уянгахишиг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, МҮХАҮТ–ын Ерөнхийлөгч Л.Төр–Од болон олон улсын санхүүгийн байгууллага, төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч, зах зээлийн мэргэжлийн оролцогчид оролцсон юм.

УИХ–ын дарга Д.Амарбаясгалан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ, эдийн засгийн тэлэлт, шударга өрсөлдөөн, санхүүгийн зах зээлийг хөхиүлэн дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал нь энэ удаагийн парламентын анхаарлын төвд байгааг онцлов. Мөн сүүлийн жилүүдэд УИХ, Засгийн газраас санхүүгийн олон тулгуурт зах зээлийг хөгжүүлэх хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаагийн сацуу хөрөнгө



оруюлагчдын итгэлийг хадгалж, идэвхийг дээшлүүлэх, оролцогчдын ойлголцол зөвшилцлийн үр дүнд бий болох санал санаачилгыг парламент дэмжин ажиллана гэдгээ илэрхийллээ.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц “Санхүүгийн зохицуулах хорооноос дотоодын томоохон компаниудыг банкны өртөг өндөр зээлийн санхүүжилтээс илүүтэй хөрөнгийн зах зээлд бонд гаргах замаар санхүүжилт татах бололцоог нэмэгдүүлэх зорилгоор богино хугацаанд бага үнийн дүнтэй бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх зэргээр тавигдах шалгуурыг багасгаж, мөн арилжаа эрхлэх байгууллагад бонд бүртгүүлэх хүсэлтийг шуурхай байдлаар шийдвэрлэдэг байх бололцоог бүрдүүллээ. Цаашид ч бондын зах зээлийг улам өргөжүүлж, компаниудын хувьд санхүүжилтээ татдаг үндсэн зах зээл, санхүүжилтийн талбар болгон олон улсын жишгийн дагуу хөгжүүлж, нийгмийн бонд, жендер бонд, тогтвортой хөгжлийн бонд зэрэг олон улсын чиг хандлагад нийцсэн бондын шинэ төрлийг нэмэгдүүлэх, бонд гаргахтай холбоотой санхүүжилтийн өртөг зардлыг багасгах, олон улсын байгууллага /ОУВС, АХБ, Дэлхийн банк зэрэг/–уудаас дотоодын зах зээлд төгрөгөөр бонд гаргахад бодлогоор дэмжлэг үзүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж байна” гэдгийг онцлов.

Форумаар Монгол Улсын бондын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн чиг хандлага, хөгжлийн бодлого, зохицуулалт, олон улсын бондын зах зээлийн чиг хандлага, нэвтрүүлэх боломж, бондод санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох ач холбогдол, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлж, жишиг хүү тогтоох ач холбогдол болон хөрөнгө оруулагч, бонд гаргагчид тулгарч буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцсэн юм. Мөн энэ үеэр СЗХ, МҮХАҮТ, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, “Монголын хөрөнгийн бирж” ХК–ийн удирдлагууд 4 талт “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгууллаа. Энэхүү санамж бичгийн хүрээнд ТӨП–100 аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр татах ажиллагааг хөнгөвчлөх, бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлагыг хялбаршуулах, зах зээл дэх засаглал, манлайллыг дэмжих, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах, хөрөнгийн зах зээлд тэдгээрийн оролцоог өсгөх, цаашлаад банкнаас бусад санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, дотоодын аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах зэргээр хамтран ажиллах юм.

“ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮГИЙН КОД”–ЫН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО

Монгол Улсын Их Хурлын даргын ивээл доор зохион байгуулагдаж буй “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код” хөтөлбөрийн нээлт Төрийн ордны “Их Монгол” танхимд боллоо. Нээлтийн үйл ажиллагаанд УИХ–



ын дарга Д.Амарбаясгалан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн болон Европын сэргээн босголт хөгжлийн банк, Монголын банкны холбооны холбогдох удирдлагууд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцов.

УИХ-ын дарга Д.Амарбаясгалан хөтөлбөрийг нээж хэлсэн үгэндээ “Олон улсад жендерийн эрх, тэгш байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа эрчимжиж, эмэгтэй эзэнтэй аж ахуйн нэгж, эмэгтэйчүүдийн жижиг бизнес эрхлэлттэй холбоотой нэр томьёо бизнесийн практик, эрх зүйн орчинд бий болж буйг онцолсон юм. Мөн Санхүү, эдийн засгийн их сургуулийн Зах зээлийн сургалт, судалгааны хүрээлэнгээс явуулсан судалгаанд эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд барьцаа хөрөнгийн дутагдал, санхүүгийн боловсролын сул байдал, бизнесийн сүлжээ, зах зээлийн хязгаарлагдмал байдал, жендерийн хэвшмэл ойлголтууд, төрийн зүгээс бодлогын дэмжлэг, хууль, эрх зүйн орчин сул зэрэг нь тулгамдсан асуудал болсныг дурдаад, эдгээр хүндрэл бэрхшээлийг даван туулахад Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Бизнесийн салбар дахь эмэгтэйчүүд”, “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код” зэрэг төсөл, хөтөлбөрүүд тодорхой үр дүн, ач холбогдлоо өгнө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ.

Харин Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц “Санхүүгийн зохицуулах хороо нь жендерийн тэгш байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч тодорхой ажлуудыг гүйцэтгэж байна. Тухайлбал, компанийн засаглалын кодексод компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэрийг хангах зохицуулалтыг тусган, салбарын зохицуулалттай байгууллагуудын статистик мэдээллийг хүйсээр ангилан гаргах тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Мөн санхүүгийн хүртээмж болон иргэдийн санхүүгийн эрүүл мэндийг үнэлэх судалгааг тогтмол гүйцэтгэж, өгөгдөл,

судалгаанд суурилсан бодлого, шийдвэрийг гаргаж байна. Үүнээс гадна, жендерт мэдрэмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор “Жендер бонд” зохицуулалтын орчныг бүрдүүлэх ажилд түлхүү анхаарч, “Бондын бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж батлахаар ажиллаж байна. Цаашид салбарын статистик, мэдээллийн ангиллыг улам нарийвчлан боловсруулж, жендерийн мэдрэмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, салбарын дүрэм журам, засаглалын шаардлагад жендерийн тэгш байдлыг тогтвортой тусгах, бизнесийн санхүүжилтийн орчин дахь жендерийн ялгааны бодит шалтгаануудыг салбарын оролцогчдод ойлгуулан, хамтдаа шийдвэрлэх чиглэлээр үр дүнтэй хамтын ажиллагааг өрнүүлэхэд уриалан ажиллана” гэдгийг онцолсон юм.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код нь дэлхийн улс орнуудын төр, санхүүгийн байгууллага, бодлого тодорхойлогчид, олон улсын хөгжлийн байгууллагууд хамтран ажиллаж, эмэгтэй бизнес эрхлэгчдийн өмнө тулгардаг санхүүгийн саад бэрхшээлийг бодитойгоор шийдвэрлэх, тэгш бус байдлыг бууруулах, жендерийн тэгш хүртээмжтэй бодлого боловсруулах хамтын ажиллагааны санаачилга юм. Тус код нь дэлхийн 30 орчим улсуудад хэрэгжиж буй бөгөөд Монгол Улс тус санаачилгад нэгдэж буй Төв Ази, Европын бүсийн 4 дэх улс болж байна. Ийнхүү манай улс санаачилгад нэгдсэнээр санхүүгийн байгууллагууд хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулж, эдгээр мэдээлэлд суурилсан бодлого боловсруулах үндэс тавигдах, жендер таксономи, эмэгтэй бизнес эрхлэгчдийн өгөгдлийн систем зэрэг олон улсын аргачлалыг нутагшуулах, үүгээр дамжуулан зохицуулагч байгууллагуудын өгөгдөлд суурилсан бодлогын чадавх сайжрах, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг хөгжлийн банкуудаас санхүү, техник туслалцаа авах суурь бүрдэнэ.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк нь тус санаачилгын ерөнхий зохицуулагчаар ажиллаж буй бөгөөд энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын төлөөлөл болсон 50 гаруй санхүүгийн



байгууллага кодоод нэгдэн гарын үсэг зурлаа. Цаашид Санхүүгийн зохицуулах хороо кодыг санхүүгийн салбарын оролцогчдоод сурталчлан таниулах, кодоод нэгдэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, хүйсээр ангилсан мэдээллийн чанарыг сайжруулж, нарийвчлалыг нэмэгдүүлэн, өгөгдөлд суурилсан бодлогын шийдвэрийг гаргах замаар санхүүгийн салбар дахь жендерийн мэдрэмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах юм.

КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТАЙЛАН ГАРЛАА

Зохицуулалттай салбарын 2024 оны комплайнсын эрсдэлийн үнэлгээний нэгдсэн тайлан гарлаа. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамрагдаж буй санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, үйл ажиллагаа эрхлэхэд комплайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг бий болгох, түүнийг хэвшүүлэх зорилтын хүрээнд “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан.

Салбаруудын комплайнсын эрсдэлийн судалгааг хийх зорилгоор даатгагч, банк бус санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын менежментийн болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудаас дээрх аргачлалын дагуу комплайнсын эрсдэлийг үнэлсэн тайлан хүлээн авсан бөгөөд үүнд үндэслэж “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ”-ний нэгдсэн судалгааны тайланг боловсрууллаа.

Комплайнс нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, түүнд нийцүүлэн, үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Түүнчлэн, комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийснээр нөхцөл, байдлыг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, үнэлгээнд үндэслэн аливаа эрсдэлтэй үйл ажиллагаагаа илрүүлэх ач холбогдолтойгоос гадна эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болох юм. Комплайнсын эрсдэлийн үнэлгээний нэгдсэн тайланг цахим хуудаснаас харах боломжтой.

ҮНДЭСНИЙ БИЧИГ БОЛОН АНГЛИ ХЭЛЭНД ХӨРВҮҮЛСЭН ГАРЫН АВЛАГЫГ ХҮРГЭЖ БАЙНА

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, оролцоо чухал үүрэгтэй. Иймээс Санхүүгийн зохицуулах хороо олон нийтэд санхүүгийн боловсрол, мэдлэг түгээх сургалт хэлэлцүүлгийг 2013 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн



сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох замаар ирээдүйд санхүүгийн зохистой шийдвэр гаргадаг, эрсдэлийг үнэлэх чадвартай иргэнийг бий болгож төлөвшүүлэх зорилгоор нэлээдгүй ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд үндэсний бичиг болон англи хэлэнд хөрвүүлсэн санхүүгийн салбарын суурь үгс бүхий гарын авлагыг сурагчдад хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээж эхлээд байна. Энэхүү гарын авлагаар дамжуулж санхүүгийн мэдлэг олгох, санхүүгийн үг хэллэгийг таниулах зорилгоор нийт ахлах ангийн сурагчдын дунд “Санхүүгийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь” сэдвийн хүрээнд үндэсний бичгээр хамгийн олон санхүүгийн үг ашигласан утга төгөлдөр өгүүлбэртэй эх бичлэгийн уралдааныг зарлаад байна. Ирэх тавдугаар сарын 31-ний өдрийг хүртэл зохион байгуулж буй уралдааны ялагчийг найруулга, үгийн сонголт болон хамгийн олон санхүүгийн үг хэллэг ашигласан байдлыг харгалзан шалгаруулах юм. Оролцогчид уралдааны бүтээлээ training@frc.mn мэйл хаягаар ирүүлэх бөгөөд ялагч “Level-Up” хөтөлбөрийн хаалтын арга хэмжээний үеэр тодорно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСЫГ НЭЭЛТТЭЙ АРИЛЖААЛАХААР БОЛЛОО

Монгол Улсын Засгийн газар найман жилийн дараа дотоодын зах зээл дээр үнэт цаас дахин гаргахаар боллоо. Засгийн газрын дунд хугацааны өрийн удирдлагын 2023–2025 оны стратегийн баримт бичгийн зорилт 4-т заасны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих, санхүүгийн зах зээлд төгрөгийн бондын суурь хүүг тогтоох зорилгын хүрээнд Сангийн яамнаас Монголын хөрөнгийн биржээр дамжуулан дотоод үнэт цаасыг энэ сарын 16-ны өдрөөс эхлэн нээлттэй арилжаалахаар боллоо.

Засгийн газраас хөрөнгө оруулагчдад тогтмол өгөөжтэй, найдвартай, эрсдэл багатай, хөрвөх чадвар өндөртэй,



хүүгийн орлогын албан татваргүй үнэт цаасыг санал болгож байгаа бөгөөд бонд эзэмшигчийн хувьд өөрийн эзэмшиж буй бондыг төлбөрийн болон бусад аливаа баталгааны барьцаа болгох боломжтой байдгаараа онцлогтой. Ийнхүү дотоодын зах зээл дээр үнэт цаасыг арилжаалж эхэлснээр суурь өгөөжийн жишиг хүү бүрдэж, бондын үнэлгээ олон улсын жишгийн дагуу тогтдог болох, цаашлаад дотоодын бондын зах зээл хөгжиж, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын нээлттэй, хаалттай хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгийн зах зээл дэх оролцоо өсөх ач холбогдолтой юм.

Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх ялангуяа бондын зах зээлийг дэмжихтэй холбоотойгоор үнэт цаас гаргагчийн зардлыг бууруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, суурь өгөөжийн жишиг хүү бий болгох, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг бэхжүүлэх чиглэлээр бодлого зохицуулалтын үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалж эхэлснээр иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд оролцох идэвхийг нэмэгдүүлэх томоохон хөшүүрэг болох юм.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ТУРШЛАГАА ХУВААЛЦЛАА

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн, Зөвлөмж 15 (Шинэ технологи)-ийн хэрэгжилтийг шинэчилсэн аргачлалаар ахиулсантай холбогдуулж Макао Улсаас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалтын талаар туршлага хуваалцах хүсэлтийг ирүүлсэн. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Макао Улсын Төв банк, тус улсын Санхүүгийн мэдээллийн алба хамтран “ФАТФ-ын Зөвлөмж 15-тай холбоотой туршлага хуваалцах уулзалт”-ыг цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Энэ үеэр Монгол Улсын виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохицуулалтын өнөөгийн нөхцөл байдал, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын туршлагаас хуваалцахын сацуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааны талаар танилцуулав. Мөн ФАТФ-аас виртуал



хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хяналт, зохицуулалтын чиглэлд анхаарал хандуулж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх стратеги, эрсдэлийг хэрхэн бууруулах, салбарт учирч буй шинэ төрлийн эрсдэл, зохицуулалтын хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл солилцсон юм. Түүнчлэн хоёр улсын дараагийн харилцан үнэлгээ 2027–2029 онд хийх болсонтой холбогдуулж хамтын ажиллагаагаа өргөжүүлэх ялангуяа эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хүрээнд хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцов.

Уулзалтад тус улсын Санхүүгийн мэдээллийн албаны дарга Конни Чү, дэд дарга Приссила Фонг, хуулийн зөвлөх Жосэ Карапинха болон Төв банкных нь Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн төлөөллүүд оролцлоо.

ЯРИЛЦЛАГА

ХАМТДАА ИЛ ТОД ЭДИЙН ЗАСГИЙГ БҮТЭЭЦГЭЭ



Манай улсын хувьд үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны худалдаа зэрэг салбар яагаад төрийн хяналт, зохицуулалтад орж, тусгай зөвшөөрөл авах шаардлагатай болсон бэ?

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–аас улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог тодорхой хугацааны давтамжтай үнэлж хянадаг ба 2024 онд шинэчлэн баталсан ФАТФ–ын 40 Зөвлөмжийн 22, 23, 28 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улс 2020 онд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбар болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарыг төрийн хяналт зохицуулалтад хамааруулсан.

Дээрх зөвлөмжийн хүрээнд улс орнууд харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлж, мэдээлэх, дотоод хяналтын тогтолцоо, сургалт, бодлогын баримт бичигтэй байх, зохицуулагч байгууллагад тайлагнах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Учир нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбар болон үнэт металл, үнэт чулууны арилжааны салбар нь санхүүгийн тогтолцооны албан бус хэсэг буюу олон улсад санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хамаардаг хэдий ч тус салбаруудаар дамжин хууль бус мөнгөний урсгал, аливаа хөрөнгүүдийн шилжилт явагдах боломжтой гэж үздэг.

Иймд олон улсын түвшинд дээрх салбаруудыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх

Хүртээмжтэй санхүү сэтгүүлийн “Байр суурь” булангийн энэ удаагийн дугаарт Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдааны салбар дахь зохицуулалтын шинэлэг бодлого, олон улсын чиг хандлагын талаар Санхүүгийн зохицуулах хорооны ҮХХЗҮЭЗГ–ын дарга Н.Энхтуяатай ярилцлаа.

зорилгоор анхаарах шаардлага үүсдэг.

Монгол Улс ч энэ жишгийг дагаж, ил тод, нээлттэй зохицуулалттай болох шаардлага үүссэн тул Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулж, “үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага”, “үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч” гэж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнийг” мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамааруулж хуульчилсан.

Хэдийгээр дээрх хуулиар зохицуулалтын хоёр салбарын үйл ажиллагаа эрхлэгчдийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамааруулаад байсан хэдий ч Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын 2019 оны 10 дугаар сарын 18–ны өдрийн хурлаар манай улсыг бидний хэлж заншсанаар саарал жагсаалт буюу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулж, 4 шууд хэрэгжилтийн хүрээнд 6 хугацаатай үүрэг даалгаврыг ирүүлсэн.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль буюу өдгөө Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг төрийн хяналт зохицуулалтад хамааруулсан.

Уншигчдад энгийнээр тайлбарлавал, яагаад дээрх хоёр салбар онцгой анхаарал татаж байна вэ?

Эдгээр салбаруудын үйл ажиллагаа нь бидний амьдралтай маш ойр бөгөөд хөрөнгө оруулалтын түгээмэл чиглэл болдог. Энэ утгаараа мөнгө угаах, татвараас зайлсхийх, хууль бус орлогыг нуун дарагдуулах зэрэг эрсдэл үүсгэдэг. Иймд дэлхий нийтээрээ эдгээр салбаруудыг хянаж, зохицуулах хэрэгцээ шаардлагатай тулгарч байгаа тул Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллагаас анхаарч ажиллахыг гишүүн орнууддаа зөвлөдөг.

Монгол Улсад энэ салбарын зохицуулалтыг сайжруулахын тулд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэргэжлийн холбоодыг чадавхжуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Цаашид иргэд, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагууд хамтран ажиллаж, шударга, ил тод, нээлттэй эдийн засгийг бий болгосноор мөнгө угаах, татвараас зайлсхийх зэрэг эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Зохих хууль, дүрэм, журмыг баталж, мөрдөх нь зөвхөн төрийн асуудал биш харин төр болон төрийн бус байгууллагууд иргэд олон нийтийн хамтын ажиллагааны хүрээнд бий болох цогц ухагдахуун бөгөөд төрийн хяналт зохицуулалтын тухайд бол холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдүүлэх, хариуцлагатай ажиллах, сургалт зохион байгуулах зэрэг нь зохицуулалттай этгээдүүдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэдэг.

Тухайлбал, харилцагчийг таньж мэдэх хуульд заасан чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадаагүйн улмаас хариуцлага хүлээх эрсдэл үүсэх боломжтой гэж ойлгож болно.

Тэгвэл жирийн иргэд, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд энэ нь ямар эрсдэл дагуулах вэ?

Хүн бүр ямар нэг байдлаар үнэт эдлэл худалдан авах эсхүл үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах үйл ажиллагаанд оролцож байна. Иймд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай ерөнхий ойлголттой байх нь Таныг болон таны гэр бүлийг учирч болох эрсдэлээс хамгаалах хөшүүрэг болно. Мөн үйлчилгээ үзүүлэгчдийн өөрсдийнх нь ч хариуцлага, эрсдэл. Та бичиг баримтгүй хүнд ажил үйлчилгээ үзүүлэх, гүйлгээ хийвэл маргааш шүүхийн өмнө хариуцлага хүлээх магадлалтай болдог эрсдэлтэй гэж ойлгож болно.

Олон улсад эдгээр салбаруудыг хэрхэн зохицуулж байна вэ?

Бүртгэл, тайлагнал, хяналт гэх гурван тулгуур зарчим бий. Их Британи, Канад, Сингапур гэх мэт улс орнууд үл хөдлөх хөрөнгө болон үнэт металл, үнэт чулууны арилжааг бүрэн бүртгэлтэй, хяналттай болгосон. Мөн Сингапурт 20,000 сингапур доллароос дээш гүйлгээ хийвэл иргэний үнэмлэх, мөнгөний эх үүсвэрийг заавал шалгадаг. Энэ нь иргэн бүрийн эрх ашиг, эдийн засгийн аюулгүй байдалд чиглэсэн маш энгийн, үр дүнтэй механизм

болдог.

Монгол Улсад энэ чиглэлийн зохицуулалт хэр хөгжиж байна вэ?

Сүүлийн жилүүдэд ахицтай алхмууд хийсэн. Санхүүгийн зохицуулах хороо энэ салбарт ажиллаж буй 800 гаруй аж ахуйн нэгж, хувь хүнийг бүртгэж, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэхдээ хууль, эрх зүйн суурь орчин, салбар хоорондын мэдээлэл солилцоо, мэргэжлийн зохицуулалт хангалттай хэмжээнд хараахан хүрээгүй байгаа олон ажлыг хийхээр төлөвлөж эхлүүлээд байна.

Тэгвэл төр ямар арга хэмжээ авах ёстой гэж та үзэж байна вэ?

Төрийн зүгээс дараах 3 чиглэлд анхааран ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Эрх зүйн орчныг шинэчлэх буюу зохицуулалтын дээрх 2 салбарын нарийвчилсан эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Бүртгэл, хяналтын системийг сайжруулах, тогтолцоог өргөн хүрээнд хөгжүүлэх мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн хамтын ажиллагаанд суурилсан систем бий болгох.

Мэргэжлийн ёс зүй, хариуцлага, сургалт, стандартыг мөрдүүлж, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд анхааран ажиллах.

Харин иргэд, аж ахуйн нэгжүүд юуг анхаарах вэ?

Иргэд, бизнес эрхлэгчид нэг зүйлийг ойлгох ёстой шинэчлэл бол дарамт биш. Харин өөрийгөө болон үйлчлүүлэгчээ хамгаалах хамгаалалтын механизм гэж ойлгож хамтарч ажиллах нь чухал байна. Харилцагчийн мэдээллийг бүртгэх, хөрөнгийн гарал үүслийг шалгах, баримт бичиг хадгалах, бүртгэл хөтлөх зэрэг нь өөрийн нэр хүнд, ирээдүйгээ хамгаалж буй үйлдэл гэдгийг ухамсарлах нь зүйтэй.

Эцэст нь, таны хувьд энэ шинэчлэлд оролцож буй хүний хувьд уншигчдад юу уриалах вэ?

Энэ бол “шаардлага” биш бид бүгд нэг зорилго дор нэгдэх цаг болсон хамтдаа шударга, ил тод эдийн засгийг бүтээхийн тулд хариуцлагатай хандвал итгэлтэй, аюулгүй хөрөнгө оруулалтын орчин бий болгох бүрэн боломжтой.

Үүний тулд хууль, эрх зүйн орчин, нэгдмэл тогтолцоо, мэдлэг гурвыг нэгтгэснээр энэ салбар зөвхөн эрсдэл биш, харин итгэлцэл, хамтын хариуцлагын цаг үе гэдгийг олон нийтэд таниулах явдал юм. Цаашлаад ФАТФ–ын зөвлөмжийн хүрээнд холбогдох хуулийн дагуу хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй ажиллаж чадвал 2027 оны “саарал жагсаалт” бидний зовлон биш, бидний сургамж болно гэж л уриалмаар байна. Баярлалаа

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ШИЛЖИЛТИЙН БОНД

Эхлэл 1-р нүүрт

Зан төлөвт суурилсан хандлага сүүлийн жилүүдэд зээлийн зах зээл дээр, ялангуяа **тогтвортой хөгжилтэй холбоотой зээлүүд (sustainability-linked loans)** зэрэг бүтээгдэхүүнүүдээр дамжин эрчимтэй тархаж байна. Хөрөнгө оруулагчид болон банкнууд “ногоон” гэж үзэхдээ зөвхөн нэг төсөл бус байгууллагын нийт үйл ажиллагаа, нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг бууруулах амлалт зэргийг улам бүр илүү анхаардаг болсон.

ШИЛЖИЛТИЙН БОНДЫН ДАВУУ ТАЛ

- ⇒ Илүү олон компанид нээлттэй: Ногоон бондын стандартад хүрэхгүй байгаа, байгальд эерэг өөрчлөлт хийх компаниуд санхүүжилт авах боломжтой.
- ⇒ Шилжилтийг дэмждэг: Нүүрсхүчлийн хий ялгаруулж буй компаниуд тодорхой хугацаанд илүү байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа руу шилжихэд чиглүүлнэ.
- ⇒ Байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах: Шилжилтийн бондын нэг давуу тал нь одоо байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг, бохирдол үүсгэж буй үйлдвэрлэл, бизнесүүд сөрөг нөлөөллөө бууруулах, үйл ажиллагаагаа ногоон болгоход зориулагддаг тул байгаль орчны сөрөг нөлөө буурах давуу талтай.

САНХҮҮЖИЛТ

- ⇒ Эдгээр бондын санхүүжилт нь сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, нүүрстөрөгчийг барих технологид хөрөнгө оруулах зэрэг компанийн шилжилтийн стратегид хувь нэмэр оруулах төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- ◆ World bank (2024), Just transition taxonomy
- ◆ Ryan Riordan, 2019. “Transition Bonds”, Available at: <https://smith.queensu.ca/>
- ◆ ICMA (2023), Climate Transition Finance Handbook

- ⇒ Санхүүжилтийн жишээ нь: Нүүрс олборлогч компани нүүрстөрөгчийг барьж хадгалахад чиглэсэн төслүүдийг шилжилтийн бондоор санхүүжүүлж болох ба эсвэл гангийн үйлдвэрлэгч шилжилтийн бондын санхүүжилтээр гангийн үйлдвэрлэлээс ялгаруулах бохирдлыг бууруулах технологид хөрөнгө оруулахад ашиглаж болно.


ШИЛЖИЛТИЙН СТРАТЕГИ

- ⇒ Шилжилтийн бонд гаргаж буй компаниуд нь тогтвортой байдлын зорилгодоо хүрэхийн тулд бондын орлогыг хэрхэн ашиглахаа тодорхойлсон тодорхой шилжилтийн стратеги, тогтолцоотой байх шаардлагатай байдаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Шилжилтийн бондын зах зээл нь хөрөнгө оруулагчид болон бонд гаргагчдын сонирхол нэмэгдэж буй тогтвортой санхүүжилтийн зах зээлийн харьцангуй шинэ, өсөж буй зах зээл юм. 2024 онд Япон улс нь шилжилтийн бондын зах зээлд дангаараа орж ирсэн бөгөөд хэмжээгээрээ хамгийн их буюу 15.1 тэрбум гаруй ам.долларын бонд гарсан нь нийт шилжилтийн бондын зах зээлийн бараг тал хувьд нь хүрсэн байна.

Annual transition bond issuance by country



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТУЗ–ИЙН 2025 ОНД АНХААРАХ 5 СОРИЛТ

Судалгааны үргэлжлэл...

Сорилт 4: ТУЗ үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэхийн сацуу төвлөрлийг хадгалах

ТУЗ–ийн засаглалын үүрэг, хариуцлагын цар хүрээ өргөжин тэлж буй энэ цаг үед тухайн компанийн стратегийн ач холбогдолтой асуудлуудад хэрхэн төвлөрч үлдэх вэ?

Хэдийгээр хууль, эрх зүйн хувьд ТУЗ–ийн үндсэн үүрэг, хариуцлага өөрчлөгдөөгүй ч эрх үүргийн хүрээ тасралтгүй тэлсээр байна. Уламжлалт удирдах түвшний асуудлаас гадна зохицуулагчдаас шаарддаг тайлагналын тоо, давтамж нэмэгдэж, оролцогч талуудаас дэвшүүлж буй асуудлууд, гэнэтийн хямралын шинжтэй нөхцөл байдал олширсноор ТУЗ–ийн хэлэлцэх асуудлын дарааллыг нэмэгдүүлж, ачаалалтай болж байна. Энэ нь компанийн хувьд чухал стратегийн асуудлуудад хангалттай цаг зарцуулах боломж хязгаарлагдаж эрсдэлийг үүсгэж болзошгүй юм.

Судалгаанд оролцсон ТУЗ–ийн гишүүдийн ихэнх нь (74%) хэлэлцэх асуудлын тоо нэмэгдсэн бол үүний зэрэгцээ тэдгээрийн хариуцаж, боловсруулах асуудлын хүрээ тэлсэн (73%) гэж хариулсан байна.

Түүнчлэн судалгааны тоо баримтаас харахад хараат бус гишүүдийн албан үүрэгтээ зарцуулж буй хугацаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өсжээ. Тухайлбал, 2015 онд жилд дунджаар 250 цагийг зарцуулж байсан бол өнөөдрийн байдлаар бараг 300 болжээ.

Гэсэн хэдий ч судалгаанд оролцсон гишүүдийн гуравны нэг нь сүүлийн таван жилийн хугацаанд ТУЗ компанийн стратегийн нэн тэргүүний асуудлуудад анхаарал хандуулахад улам төвөгтэй болж байна гэж хариулжээ.

ТУЗ–ийн хэлэлцэх асуудал, боловсруулах баримт бичгийн хэмжээ ихэссэнтэй холбоотойгоор хэд хэдэн ТУЗ–ийн бүрэлдэхүүнд ажиллаж буй гишүүдийн хувьд ачаалал үүсэж, гишүүнийхээ ажил үүргээ бүрэн гүйцэтгэж чадахгүй байх эрсдэл нэмэгдсээр байна.

Анхаарах зүйлс:

ТУЗ цаг хугацаа, нөөц бололцоогоо хэрхэн хуваарилж байгаад онцгой анхаарал хандуулах нь урьд өмнөхөөсөө илүү чухал болж байна. ТУЗ жилийн ажлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудлыг ач холбогдлоор тодорхойлох, мэдээлэл, тайлагналын үйл явцыг эргэн нягтлах хэрэгтэй.

ТУЗ жил бүрийн ажлын төлөвлөгөөгөө тодорхой давтамжтайгаар хянаж, шаардлагатай бол шинэчилж байх шаардлагатай. Ихэнх ТУЗ өмнөх жилийн хурлын хуваарь дээр үндэслэн дараагийн жилийн хөтөлбөрийг боловсруулдаг. Энэ нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын багт жилийн турш зохион байгуулах хурал, уулзалтыг цогцоор нь төлөвлөх боломжийг олгодог. ТУЗ хуваарьт ажлуудыг зөвхөн өнгөрсөн үйл явдал болон зохицуулалтад голчлон төвлөрөхөөс зайлсхийж, компанийн стратегийн хувьд чухал шинэ асуудлууд дээр ил тод ярилцах орон зайг бий болгохыг зорих шаардлагатай. ТУЗ, эсвэл хороодын хурлын жагсаалтад нэмэгдэж буй шинэ асуудлыг компанийн стратеги, эрсдэлийн удирдлагатай уялдуулан авч үзэх нь зөв.

ТУЗ нь ажлын цаг хугацаагаа төлөвлөх, хурлын жагсаалт, хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулахдаа үргэлж стратегийн хандлагаар гүйцэтгэж, ТУЗ–ийн нарийн бичгийн даргатай хамтран ТУЗ–ийн хуралд зарцуулагдаж буй хугацааг хянаж, гишүүдээс санал бодлыг тогтмол авах нь хэлэлцэх асуудлыг оновчтой тодорхойлоход тустай.

NACD–ийн 2024 оны “ТУЗ–ийн үйл ажиллагаа ба хяналт” судалгаагаар ТУЗ–ийн ердөө 13 хувь нь өөрсдийн тайланг “маш үр дүнтэй” гэж үнэлжээ. Иймд ТУЗ–ийн гишүүд тайлангийн шинэ стандартыг тогтоохын тулд гүйцэтгэх удирдлагын баг болон ТУЗ–ийн нарийн бичгийн даргатай хамтран ажиллах шаардлагатай.

Үргэлжлэл бий..

Эх сурвалж: www.nacdonline.org

ФИНТЕК БА РЕГТЕК

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ БА КИБЕР ЭРСДЭЛ

Санхүүгийн байгууллагууд дижитал шилжилтийг эрчимтэй хийж байгаа энэ үед зөвхөн шинэ технологи нэвтрүүлэхээс гадна түүнийг хамгаалах шаардлага ч өсөн нэмэгдэж байна. Үүлэн тооцоолол, хиймэл оюун ухаан (AI), дараа үеийн программ хангамж зэрэг шинэ технологиудыг нэвтрүүлэх ажил санхүүгийн байгууллагуудын дунд ид өрнөж буй ч түүнийг дагаж ирэх кибер эрсдэлийг давхар тооцох шаардлагатай болж байна.

Энэ талаар Олон улсын санхүүгийн хүрээлэн (IIF) болон МакКинси&Компани (McKinsey & Company)-ийн хамтарсан “Кибер цаг хугацаа урсаж байна” (“The Cyber Clock Is Ticking”) судалгааны үр дүн санхүүгийн байгууллагууд технологийн шинэчлэлд хурдацтай шилжиж байгаа ч нөгөө талаас кибер аюулгүй байдлын хувьд хоцрогдолтой хэвээр байгааг харуулсан.

Уг судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын хувьд дараах 2 асуудлыг хөндсөн юм. Нэгдүгээрт, нийт судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын 70 хувь нь кибер аюулгүй байдалд хангалттай хөрөнгө зарцуулахгүй байгаа талаар дурдсан бол нөгөө талаар мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай болохыг судалгаанд хамрагсдын 65 хувь нь илэрхийлсэн байна (Atkins et al., 2024). Учир нь ихэнх байгууллага үүлэн тооцооллын үйлчилгээ үзүүлэгчид бүх хамгаалалтыг хийдэг гэж андуурдаг ч бодит байдал дээр өөрсдөө хамгаалалтын хариуцлага хүлээх шаардлагатай болдог учраас кибер аюулгүй байдлыг чухалчилсан. Харин энэ чиглэл дэх мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх асуудлын тухайд авч үзвэл, зарим байгууллагууд нь хиймэл оюун ухаан (AI)-ы тусламжтайгаар хамгаалалтын үйл ажиллагааг автоматжуулж, мэргэшсэн боловсон хүчний дутагдлыг нөхөхөөр ажиллаж байгаа ч хиймэл оюун ухаан (AI) нь өөрөө эрсдэл дагуулдаг учир хүний нөөцийг бэлтгэх асуудлыг зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үзжээ.

Мөн судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын хувьд шинээр нэвтрүүлж байгаа болон тус салбарынхны анхаарлын төвд байгаа технологиудыг дурдсаныг авч үзвэл, нийт судалгаанд хамрагсдын 84 хувь нь үүлэн

тооцоолол болон захын (edge) тооцоолол, 78 хувь нь хэрэглээнд суурилсан хиймэл оюун ухаан (AI), 73 хувь нь дараа үеийн программ хангамж хөгжүүлэлт, 70 хувь нь дижитал итгэлцлийн архитектур ба цахим танилт гэж тус тус хариулсан. Тодруулбал,

1. Үүлэн болон захын (edge) тооцоолол



Үүлэн тооцоолол гэдэг нь байгууллага мэдээллээ өөрийн сервер дээр биш, интернэтэд байрлах том дата төвүүдээр

дамжуулан хадгалж, боловсруулдаг систем юм. Харин захын тооцоолол нь тухайн өгөгдлийг хэрэглэгчийн гар утас, мэдрэгч, камер зэрэг төхөөрөмж дээр шууд боловсруулж, төв серверт ачаалал өгөхгүйгээр хурдан шийдвэр гаргах боломжтой болгодог. Энэ хоёр технологи нь үйл ажиллагааг илүү уян хатан, хурдан, хямд болгодог тул санхүүгийн байгууллагууд нэвтрүүлж эхэлсэн. Нөгөө талаар үүлэн болон захын тооцооллын орчинд сүлжээний уламжлалт хамгаалалт (жишээлбэл, дотоод серверийн ханын хамгаалалт) үр дүн багатай болж, гаднаас халдах олон шинэ “оролтын цэг” (attack surface) үүсдэг. Хэрвээ байгууллага бүрэн хяналтгүйгээр өгөгдөл дамжуулж, хадгалж байвал зөвхөн нэг цэгийн сул тал бүх сүлжээг эрсдэлд оруулах боломжтой.

2. Хэрэглээнд суурилсан хиймэл оюун ухаан (AI)



Хиймэл оюун ухаан нь их хэмжээний өгөгдөл суурилан ухаалаг шийдвэр гаргах, хэрэглэгчийн зан төлөвийг шинжлэх, луйвар илрүүлэх, чатботоор дамжуулан хэрэглэгчтэй харилцах зэргээр олон

салбарт ашиглагдаж байна. Санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухаан (AI)-ыг зээлийн эрсдэлийн үнэлгээ,

автомат зөвлөмж өгөх, хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулахад өргөн ашиглаж байгаа бөгөөд цаашид үүний хэрэглээ улам нэмэгдэх хандлагатай. Гэвч нөгөө талаас хиймэл оюун ухаан (AI) нь хуурамч и-мэйл бичих, фишингийн компанид ажилд ашиглах, хуурамч дуут болон дүрст мэдээлэл үүсгэх зэргээр хэрэглэгчийг хуурах гэх мэт эрсдэл үүсдэг.

3. Дараа үеийн программ хангамж хөгжүүлэлт



Орчин үеийн программ хангамжийн хөгжүүлэлтийн хэрэгслүүд нь код бичих, байршуулах,

турших, орчуулах болон дахин боловсруулах процессыг автоматжуулж, хялбарчилдаг. Жишээлбэл, тасралтгүй нэгтгэх, байнгын хүргэлтийн дамжуулах шугам, (CI/CD pipeline), бага код шаарддаг, эсхүл кодгүй платформууд (low-code/no-code платформууд), мөн хиймэл оюун ухаан (AI) код туслагч зэргийг ашигласнаар программ хангамжийн хөгжүүлэлтийг улам хурдан, хэмнэлттэй болгодог. Хэрвээ автоматжуулалт, код үүсгэгч хэрэгслүүдийг зохих хяналтгүй ашиглавал хамгаалалтын алдаа гарах, сул код системд нэвтрэх зэрэг эрсдэл үүсэж болзошгүй. Жишээлбэл, Хиймэл оюун ухаан (AI)-аар бичүүлсэн код нь аюулгүй байдлын стандарт хангахгүй байж, халдлагад өртөх боломжийг бүрдүүлнэ.

4. Цахим танилт ба итгэлцлийн архитектур



Цахим танилт болон итгэлцлийн архитектур нь хэрэглэгчийг цахимаар найдвартай таних, мэдээллийн аюулгүй

байдлыг хангах үндсэн технологиуд юм. Үүнд нүүр царай таних, хурууны хээ, 2 шатлалт баталгаажуулалт (2FA), цахим гарын үсэг, тоон гэрчилгээ, итгэлцлийн платформ зэрэг шийдлүүд хамаарна. Хэрвээ цахим танилт болон итгэлцлийн систем буруу хэрэгжсэн бол хуурамч хэрэглэгч системд нэвтрэх, биеийн онцлог мэдээлэл (биометрийн өгөгдөл) алдагдах, итгэлцлийн гинжин систем доголдох эрсдэлтэй.

5. Аж үйлдвэрийн зориулалттай машин сургалт



Аж үйлдвэрийн зориулалттай машин сургалт (Industrialized machine learning) нь хиймэл оюун ухаан болон

машин сургалтын шийдлүүдийг томоохон байгууллагуудын түвшинд үр ашигтай, найдвартай, өртөг багатай, хурдтай нэвтрүүлэхэд чиглэсэн систем, аргачлал юм. Хэрвээ машин сургалтын өгөгдөл буруу эсвэл зориудаар гажуудсан (data poisoning) байвал, хиймэл оюун ухаан (AI) модель алдаатай шийдвэр гаргаж, системийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн хиймэл оюун ухаан (AI)-ы сурсан загварууд руу халдах замаар (model inversion, adversarial attacks) дотоод мэдээллийг сэргээх, гүйцэтгэлийг зориуд бууруулах боломж бий. Хамгийн гол нь, эдгээр системүүд их хэмжээний эмзэг өгөгдөл ашигладаг тул өгөгдлийн хамгаалалт, нэвтрэх эрхийн хяналт маш өндөр түвшинд байх ёстой.

Эх сурвалж:

Atkins, L., Banerjee, S., Craig, L., Greis, J., & Hao, G. (2024, March 11). The cyber clock is ticking: Derisking emerging technologies in financial services. McKinsey & Company. <https://www.mckinsey.com/capabilities/risk-and-resilience/our-insights/the-cyber-clock-is-ticking-derisking-emerging-technologies-in-financial-services>

СУДЛААЧИЙН ИНДЭР

ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАЛТ БА ОЛОН УЛСАД

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт П.Байгалмаа

ХУРААНГУЙ

Блокчейн технологи нь хөрөнгийн зах зээлийн дэд бүтцэд хувьсал хийж байна. Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд оролцогчид түүний төлбөр тооцоо шуурхай хийх, бүртгэл хөтлөлт, өгөгдлийг нэгтгэх зэрэг үйлдлүүдийг нь үнэт цаас гаргах, үнэт цаасны гүйлгээ хийхэд ашиглах сонирхол нэмэгдэж байна. Тиймээс зарим улс орны зохицуулагч байгууллагууд блокчейн технологийг ашиглан үнэт цаасны амьдралын мөчлөгийг хөнгөвчлөх, ашиг тусыг хүлээн зөвшөөрч, хяналт зохицуулалтыг нь уламжлалт үнэт цаасны хуулийн хүрээнд хамруулах, эсхүл шинээр тогтоох болон хослуулан ашиглаж байгаа ба дижитал үнэт цаасны үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд уг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022–2025 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний Зорилт 1. “Уян хатан зохицуулалт, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг дэмжих”-ийн Дэд зорилт 1.1.3-т “цахим технологид суурилсан болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих, технологийн стандартыг нэвтрүүлэх” гэж тусгасан.

Энэхүү Дэд зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Токенжуулсан үнэт цаасны зохицуулалт ба олон улсын туршлага” гэсэн сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Уг судалгаагаар токенжуулсан үнэт цаас, түүний зохицуулагч байгууллага, зохицуулалтын эрх зүйн актууд, зах зээлд нэвтэрсэн болон хууль зөрчсөн токenuуд зэрэг холбогдох мэдээллийг хүргэх төдийгүй судлаачийн зүгээс санал дэвшүүлэх болно.

УДИРТГАЛ

Токенжуулалт нь блокчейн технологийг ашиглан үнэт цаасыг уламжлалт амьдралын мөчлөгөөс дижитал хэлбэрт шилжүүлж, илүү үр ашигтай, өргөжих боломжтой, инновац шингэсэн хөрөнгө босгох арга хэлбэр болж байна. Boston Consulting Group-ийн тооцоогоор 2030 он гэхэд дэлхийн ДНБ-ий 10 хувь нь (ойролцоогоор 16 их наяд ам.доллар) токенжуулна гэж үзжээ.

Энэхүү судалгаанд АНУ, ЕХ, Сингапур, Япон, Хонконг зэрэг орнуудын токенжуулсан үнэт цаасны зохицуулалт, түүний зах зээлийн чиг хандлага хамруулан судалсан. Эдгээр орнуудын бодлого боловсруулагч болон зохицуулагч байгууллага нь токенжуулсан үнэт цаасыг өмчлөлийн эрх илэрхийлдэг үнэт цаас гэж үзэн хууль, тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, зохицуулдаг ба зах зээлийн тогтвортой байдал, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад анхаарч ажиллаж байна. Монгол Улсын хувьд токенжуулалтын дэд бүтэц бүрдсэн ч зохицуулалт тодорхой бус байдалтай байна.

Судалгаанд дараах гол асуултуудыг хөндсөн:

1. Токенжуулсан үнэт цаасны мөн чанар, зах зээлийн үйл ажиллагаа, давуу ба сул талууд, эдийн засгийн үр нөлөө
2. Сонгогдсон орнуудын зохицуулагч байгууллагууд ба эрх зүйн зохицуулалтын харьцуулалт
3. Амжилттай хэрэгжсэн болон хууль зөрчсөн токены жишээ

Монгол Улсын хувьд хэрэглээний тохиолдол, эмпирик өгөгдөл хангалтгүй тул индуктив аргыг энэхүү судалгаанд баримталлаа.

ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААС

Токенжуулсан үнэт цаас бий болсноор дэлхийн зах зээлд хөрөнгө оруулалт, худалдаа хийх арга хэлбэр өөрчлөгдөж байна.

Токенжуулсан үнэт цаас, түүний төрөл

Уламжлалт санхүүгийн системд хөрөнгийн эзэмшил, шилжилтийг төвлөрсөн байгууллагууд (банк, бирж, төлбөрийн төвүүд) хариуцдаг. Энэ нь цаг хугацаа шаардсан, зардал өндөртэй, хүртээмжийн хувьд жижиг хөрөнгө оруулагчдад хязгаарлагдмал байдаг. Харин блокчэйн технологид суурилсан токенжуулалт нь энэ асуудлыг шийдэж, хөрөнгийн зах зээлд дэлхий даяар хэн ч нэвтрэх боломжийг олгодог. Токенжуулсан үнэт цаас нь:

- ⇒ Бодит хөрөнгийн өмчлөлийг илэрхийлдэг,
- ⇒ Хууль эрх зүйн зохицуулалттай,
- ⇒ Мэдээллийг найдвартай, өөрчлөгдөшгүй хадгалдаг.

Токенжуулсан үнэт цаас эзэмшигч нь уламжлалт үнэт цаас эзэмшигчтэй ижил эрх эдэлнэ. Одоогоор дэлхий нийтэд нэгдсэн ангилал байхгүй ч ихэнх улс оронд дараах төрлүүдэд хуваадаг:

- ⇒ Хувьцаа
- ⇒ Корпорацын бонд
- ⇒ Төрийн сангийн үнэт цаас
- ⇒ Сангийн нэгжүүд
- ⇒ Хөрвөх бонд

Токенжуулсан үнэт цаасны давуу ба сул тал

Азийн хөгжлийн банкны хүрээлэнгээс 2020 онд гүйцэтгэсэн “Блокчейн ба токенжигдсон үнэт цаас: Ногоон санхүүжилт татах боломж” (Gatteschi et al. 2018; Niranjana Murthy, and Jagannatha 2018; Duchenne 2018) судалгаанд дурдсанаар хэд хэдэн судалгаанд үндэслэсэн анхны удаа SWOT шинжилгээ ашиглан токенжуулсан үнэт цаасны давуу болон сул талуудыг илрүүлсэн

Хүснэгт 1. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
Ил тод байдал, өөрчлөгдөхгүй байдал, аудит хийх боломжтой ухаалаг гэрээгээр үр ашигтай ажиллаж, гүйлгээний зардлыг буурах програмчлах чадвар, зохицуулалтын нийцтэй байдал	Шинэ технологи, ойлголт, ухамсар платформууд болон зуучлалын ажиллагаа хэрэглэгчийн туршлага, интерфейс Fiat гарц мэдээлэл цэвэрлэх асуудал зохицуулалтын тодорхойгүй байдал
Боломж	Аюул занал
Шинэ хөрөнгө оруулагчаар дамжуулан хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх бусад шинээр гарч ирж буй технологиудыг нэгтгэх Дэлхийн хөрөнгө оруулагчдын бааз ба хэсэгчилсэн өмчлөлийн тусламжтайгаар хөрвөх чадварыг нэмэгдүүлэх алтернатив санхүүгийн дэд бүтэц жижиг дунд төслүүдэд хөрөнгө босгох уян хатан байдал	Сул талуудыг арилгах ахиц дэвшлийг саатуулж байна зохицуулалтын тодорхойгүй байдал ба болзошгүй хориг

Эх үүсвэр: <https://www.adb.org/sites/default/files/publication/566271/adbi-wp1079.pdf>

Токенжуулсан үнэт цаас (ТҮЦ) нь блокчейн технологид суурилсан, төвлөрсөн бус дэд бүтцэд тулгуурладаг бөгөөд уламжлалт үнэт цаастай (ҮҮЦ) харьцуулахад дараах үндсэн ялгаатай байдалтай:

Үзүүлэлт	Уламжлалт үнэт цаас (ҮҮЦ)	Токенжуулсан үнэт цаас (ТҮЦ)
1. Технологи ба дэд бүтэц	Төвлөрсөн байгууллагуудаар (бирж, брокер, тооцооны төв) дамждаг.	Блокчейн дээр суурилсан, дижитал токен хэлбэртэй, төвлөрсөн бус дэд бүтэцтэй.
2. Гаргах ба өмчлөх эрх	Гар ажиллагаа ихтэй, зуучлагч оролцсон төвөгтэй процесс.	Ухаалаг гэрээгээр автоматажсан, шууд өмчлөх боломжтой, зуучлагч шаардлагагүй. Зардлын бууралт (жишээлбэл: бонд гаргах зардлыг 90% хүртэл, хөрөнгө босгох зардлыг 40% хүртэл бууруулах боломжтой).
3. Арилжаа ба төлбөр тооцоо	Олон зуучлагч оролцдог, төлбөр тооцоо удаан (T+2 / T+3).	Peer-to-peer арилжаа, T+0 горимоор шуурхай төлбөр тооцоо.
4. Хөрвөх чадвар ба зах зээлд нэвтрэх	Хязгаарлагдмал хөрвөх чадвар, цаг хугацаанд хамаардаг.	24/7 арилжаалагддаг, бутархай эзэмшил боломжтой, хил дамнасан гүйлгээг дэмжих ба дэлхий даяар хандалттай өргөн хүртээмж бий болгодог.
5. Зохицуулалт ба дагаж мөрдөх	Тогтсон хууль, зохицуулалтаар удирдуулдаг.	Хөгжиж буй зохицуулалт, sandbox туршилт, ухаалаг гэрээгээр автомат дагаж мөрдөлт боломжтой.
6. Ил тод байдал ба аюулгүй байдал	Ил тод бус, төвлөрсөн бүртгэл, гар ажиллагаа давамгайлдаг.	Ил тод, бодит цагийн бүртгэл, криптографийн хамгаалалттай, найдвартай тул хөрөнгө оруулагчийн итгэлийг нэмэгдүүлдэг.

Токенжуулсан үнэт цаас нь уламжлалт үнэт цаастай харьцуулахад технологийн дэвшлийг ашиглаж, арилжаа, өмчлөл, ил тод байдал, хүртээмж зэрэг олон чиглэлд томоохон давуу талууд байгаа ч дараах болзошгүй эрсдэлүүд байна. Үүнд:

- ⇒ Зохицуулалтын тодорхой бус байдал – ТҮЦ–д зориулсан хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй.
 - ⇒ Аюулгүй байдлын эрсдэл – Кибер халдлагад өртөх магадлалтай.
 - ⇒ Зах зээлийн тогтворгүй байдал – Харьцангуй шинэ зах зээл тул үнэ ханш нь хэлбэлзэлтэй байж болзошгүй.
 - ⇒ Хөрвөх чадварын бодит асуудал – Зах зээл болон платформын хөгжлөөс хамаарч байна.
- Мэдлэгийн дутагдал – Хөрөнгө оруулагчдын дунд шинэ технологийг ойлгох, ашиглах чадвар сул байж магадгүй.

ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААС ҮҮСГЭХ БА ГАРГАХ

Үнэт цаасыг хэрхэн токенжуулдаг үйл явцыг тоймлоё. Токенжуулалт гэж хөрөнгийг олон жижиг хэсэг болгон задалж, токен болгон хөрвүүлэх үйл явц юм. Эдгээр токenuуд нь хөрөнгийн эзэмшлийн тодорхой хувь эсвэл ашиглах эрхийг илэрхийлдэг.

1. Төлөвлөлт

Үнэт цаас сонгох: Блокчэйнд тохиромжтой, эрсдэл багатай, хөрвөх чадвар өндөртэй үнэт цаасыг сонгоно. Жишээ: энгийн болон давуу эрхтэй хувьцаа.

Токенжуулахын зорилгыг тодорхойлох: Хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэх, гүйлгээний зардлыг багасгах, хөрвөх чадварыг сайжруулах гэх мэт.

Үнэлгээ, хууль эрх зүй: Үнэ цэнийг тогтоож, SEC, AML, KYC зэрэг хууль, дүрэм журмыг дагаж мөрдөнө.

2. Токен үүсгэх процесс

Блокчэйн платформ сонгох: Ethereum, Binance Smart Chain, Polygon, Tezos зэрэг.

Токены тодорхойлолт: Токены нэр, тэмдэг (symbol), ширхэг, стандарт (ERC-20, ERC-721, ERC-1400).

Ухаалаг гэрээ боловсруулах: Токены гүйлгээ, өмчлөлийг удирдах гэрээг бичиж, блокчэйнд байршуулна.

KYC/AML баталгаажуулалт: Хөрөнгө оруулагчдын мэдээллийг шалган баталгаажуулна.

3. Зах зээлийн арилжаа

Анхдагч зах зээл: Токеныг анхдагч бирж дээр санал болгож хөрөнгө оруулагчдад борлуулна.

Хоёрдогч зах зээл: Токеныг 24/7 цагийн турш хөрөнгө оруулагч хоорондоо арилжаалах боломжтой болно.

4. Зах зээлд нэвтэрсний дараа

Өмчлөлийн хяналт: Токены шилжилт, эзэмшлийг блокчэйн дээр бүртгэнэ.

Санхүүгийн зохицуулалт: Ухаалаг гэрээгээр ногдол ашиг, саналын эрх, тайлагнал зэргийг автоматжуулна.

Аюулгүй байдал: Хакерын халдлагаас сэргийлэх, системийн найдвартай байдлыг хангах ажиллагаа хийнэ.

Хөрвөх чадвар: Биржүүд дээр арилжаалагдсанаар токены эрэлт, үнэ тогтворжиж, хөрөнгө оруулагчдад хялбар гүйлгээ хийх боломж бүрдэнэ.

Токенжуулсан үнэт цаасны эдийн засгийн үр өгөөж

Уламжлалт үнэт цаас нь санхүүгийн зах зээлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлага, эдийн засгийн өсөлт, ажлын байр, инновац зэрэгт чухал хувь нэмэр оруулдаг. Хөрөнгө оруулагчдад орлого олох, эдийн засагт хөрөнгө оруулалт татах, санхүүжилт олгох, зах зээлийн ил тод байдал, хамгаалалтыг сайжруулах замаар нийгмийн хөгжил, санхүүгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлдөг.

Тэгвэл токенжуулсан үнэт цаас нь уламжлалт санхүүгийн системд шинэчлэл авч ирж, эдийн засагт үзүүлж буй үр өгөөжийг нь дурдвал:

1. Хөрвөх чадварын нэмэгдэл – Үнэт цаасыг хувааж хэсэгчлэх эзэмших боломжтой болсноор илүү олон хүнд хүртээмжтэй хөрөнгө оруулалт хийх боломж олгож, дижитал платформоор 24/7 арилжаалж хөрвөх чадвар нэмэгддэг.
2. Зах зээлийн үр ашгийн өсөлт – Блокчейн ба ухаалаг гэрээ нь зуучлагчдыг халж, үйл явцыг автоматжуулснаар зардлыг бууруулж, гүйлгээний хугацааг хурдасгадаг. Ил тод байдал нь залилангийн эрсдэлийг бууруулж, итгэлцлийг нэмэгдүүлдэг.
3. Зохицуулалт ба аюулгүй байдал – Токенууд ухаалаг гэрээгээр автоматаар хууль, зохицуулалтыг дагаж мөрдөнө. Блокчейн нь шифрлэгдсэн, өөрчлөгдөх боломжгүй бүртгэлээр аюулгүй байдлыг хангадаг.

Эдгээр шинэлэг өөрчлөлтүүд нь токенжуулсан үнэт цаасыг санхүүгийн экосистемийн ирээдүйн чухал бүрэлдэхүүн хэсэг болгож байна.

ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАЛТ БА ОЛОН УЛСАД


Улс орнууд токенжуулсан үнэт цаасны боломжит ашиг тусыг хүлээн зөвшөөрч, хөрөнгө оруулагчдыг хохирлоос хамгаалахын зэрэгцээ салбарын инновац, өсөлтийг дэмжиж зохицуулахаар ажиллаж байна.

ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Токенжуулсан үнэт цаас нь блокчейн, крипто технологид суурилсан үнэт цаасны шинэ хэлбэр бөгөөд уламжлалт санхүүгийн зах зээлийг илүү хүртээмжтэй, ил тод болгох боломжийг бүрдүүлдэг. Хөрөнгө оруулагчдад ашиг хүртэх болон зах зээлийн өсөлтөөс өгөөж авах боломж олгодог тул сонирхол нэмэгдэж, зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлж байна.

Boston Consulting Group-ийн таамаглалд дурдсанаар 2030 он гэхэд дэлхийн ДНБ-ий 10 хувь нь токенжих буюу 16 их наяд ам.долларын хөрөнгө токенжуулагдана гэсэн бол Business Research Insights-ийн мэдээлснээр, токенжуулсан үнэт цаасны зах зээл 2024 онд 5.6 тэрбум ам.доллароор үнэлэгдсэн бол 2032 он гэхэд 22.5 тэрбум ам.долларт хүрч, жил бүр дунджаар 19 хувиар өсөх төлөвтэй байна гэжээ.

Зураг. Дэлхийн токенизуулсан үнэт цаасны зах зээлийн хэмжээ



Эх үүсвэр: <https://www.businessresearchinsights.com/market-reports>

Токенизуулсан үнэт цаасны зах зээл хурдацтай өсөхийн хэрээр зохицуулалтын хэрэгцээ нэмэгдэж байна. Үүнд:


- ⇒ Хөрөнгө оруулагчийг хамгаалах: Ил тод байдал, эрсдэлийн мэдээлэл, зохицуулагчийн идэвхтэй хяналт шаардлагатай.
- ⇒ Зах зээлийн тогтвортой байдал: Үнэлгээ, шилжүүлгийн тодорхой дүрэм хэрэгтэй.
- ⇒ Хууль ёсны тодорхой байдал: Токенизуулалт ямар нөхцөлд үнэт цаас болох, блокчейны аюулгүй байдлын шаардлага чухал.
- ⇒ AML/KYC: Мөнгө угаалт, терроризмын санхүүжилтийг хязгаарлахад заавал хэрэгжүүлэх шаардлагатай.

Олон улсын нийцэл: Хил дамнан арилжаанд уялдаа холбоо шаардлагатай.

Одоогоор нэгдсэн зохицуулалтын тогтолцоо бүрдээгүй ч олон улс орон токенизуулсан үнэт цаасыг уламжлалт үнэт цаасны хууль тогтоомжид хамруулан зохицуулж байна. АНУ, ЕХ зэрэг нь иж бүрэн зохицуулалт боловсруулах чиглэлд ахицтай ажиллаж байгаа бол бусад улс бодлогын эхний шатандаа байна.

Дэлхийн улс орнуудын токенизуулсан үнэт цаасны эрх зүйн зохицуулалтыг

Зураг. Токенизуулсан үнэт цаасны эрх зүйн зохицуулалттай улс орон



Эх үүсвэр: <https://blog.stomarket.com/defining-security-tokens-list-of-all-countries-with-legal-definitions>

Олон улсын туршлага

Дэлхийн токенжуулсан үнэт цаасны зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг илэрхийлж буй АНУ, Европын холбоо, Сингапур, Япон, Хонконг зэрэг улс орны туршлагаас авч үзье:

Улс	Гол зохицуулагчид	Гол зохицуулалт	Дүгнэлт
АНУ	SEC, FINRA, CFTC, FinCEN, UCC	<ul style="list-style-type: none"> SEC: Дүрэм D, S, A+ FINRA: Брокер, дилер CFTC: Барааны токен FinCEN: AML/KYC UCC: Арилжааны гүйлгээ 	Нэгдсэн удирдамжгүй ч, олон байгууллага хамтран ажиллаж, хөрөнгө оруулагч хамгаалж, инновацыг дэмжиж байна.
ЕХ	ESMA, EBA, ECB	<ul style="list-style-type: none"> MiCA, MiFID II, MAR, PSD2, Prospectus Reg, GDPR DLT туршилтын дүрэм (2023) 5AMLD: AML/KYC 	Хамгийн иж бүрэн, уялдаа бүхий зохицуулалттай. Зах зээлийн ил тод байдал, аюулгүй байдал сайн хангагдсан.
Сингапур	MAS, SGX	<ul style="list-style-type: none"> SFA, PSA “Ижил эрсдэл – ижил зохицуулалт” Сэндбокс зохицуулалт 	Уян хатан, инновац дэмжсэн бодлого хэрэгжүүлж, финтек хөгжлийг дэмжиж байна.
Япон	JFSA, JVCEA	<ul style="list-style-type: none"> FIEA: Зохицуулалт, зөвшөөрөл PSA: AML, хэрэглэгчийн эрх Хууль зөрчсөнд хариуцлага өндөр 	Хатуу, тодорхой зохицуулалттай. Ил тод байдал, хөрөнгө оруулагчийн хамгаалалт өндөр түвшинд тавьсан.
Хонконг	SFC, HKMA	<ul style="list-style-type: none"> SFO дагуу тусгай зөвшөөрөл 2023 оны шинэчилсэн SFO, Guidance Туршилтын орчин 	Хатуу хяналт, зөвшөөрлийн тогтолцоотой. Технологийн туршилыг дэмждэг.
Монгол	СЗХ, Монголбанк	<ul style="list-style-type: none"> Төлбөрийн системд токенжуулалт хийгдсэн Сэндбокс орчинд турших боломжтой. 	Тусгай зохицуулалт байхгүй.

ЗАХ ЗЭЭЛД НЭВТЭРСЭН ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ БОДИТ ЖИШЭЭ

Үнэт цаасыг блокчэйн дээр цахим токен болгон хувиргах үйл явц сүүлийн үед маш хурдацтай явагдаж байна. Уламжлалт үнэт цаасыг токенжуулснаар үр ашиг, хүртээмж нэмэгддэг талаар өмнөх бүлгүүдэд дурдсан.

Энэ бүлэгт хөрөнгө босгох болон бусад зорилгод зориулж токенжуулсан үнэт цаас гаргасан бодит жишээнүүдийг өгүүлэх болно.

Компанийн нэр / Токен	Гарсан он	Үндсэн платформ / Технологи	Токены зорилго, ашиг тус	Хөрөнгө оруулалт / Үнэлгээ	Бирж / Арилжаа
tZERO (TZROP)	2018	tZERO платформ (блокчэйн)	Ногдол ашиг, ил тод арилжаа, өмчийн эзэмшил	134 сая ам.доллар	OTCMKTS бирж (3.0 USD)
NYALA	2023	ЕХ-ны блокчейн, API үйлчилгээ	Токенжуулсан хувьцаа, институциональ үйлчилгээ	Мэдээлэл дутуу	INX бирж (141.98 USD)
INX токен	2020	Төвлөрсөн ба төвлөрсөн бус биржүүд төлбөрт ашиглах	Хувьцаа, эрхийн хөрөнгө эзэмших, зориулалттай	85 сая ам.доллар (7,200 хөрөнгө оруулагч, 75 орон)	INX бирж (0.16 USD)
Siemens дижитал бонд	2023	Polygon (блокчэйн), Германы хууль	ESG дэмжлэгтэй, ил тод, зуучлагчгүй арилжаа	60 сая евро	Шууд хөрөнгө оруулагчдад хүрсэн
Хонконгийн ногоон бонд	2023	Олон валют: USD, EUR, CNY, HKD	Тогтвортой хөгжил, олон валютын дижитал бонд	766.8 сая ам.доллар	Нэр дурдагдаагүй
Swarm Markets (U.S. бонд)	2024	Polygon блокчэйн	Жижиглэнгийн хүртээмж, ISIN стандарт, 4.5% өгөөж	Мэдээлэл дутуу	Swarm бирж
ICTG токен (АйСиТи Групп)	2021	trade.mn крипто бирж	Хувьцаанд хөрвөх, токен хэлбэрээр арилжаалах	130₮ 30.10₮ (4 дахин уналт)	Trade.mn бирж

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГААГҮЙ ТОКЕНЖУУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ЖИШЭЭ

Энэ бүлэгт зохицуулагч байгууллагаас хууль тогтоомжоор хүлээсэн нөхцөл шаардлагыг хангуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар зарим жишээг авч үзжээ.

1. Kin token (Kik Interactive): Kik Interactive компанийн Kin token нь хэрэглэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой дижитал валют байв. 2019 онд SEC хэргийг шалгаж, Kik компанийн 55 сая ам.доллар татан төвлөрүүлснийг хууль бус гэж үзэж, 5 сая ам.долларын торгууль ногдуулсан.
2. Grams token (Telegram Group Inc): Telegram-ийн Grams token нь блокчэйн дээрх хурдтай гүйлгээний системийг бий болгох зорилготой байв. SEC хэргийг зогсоосон бөгөөд Telegram 1,224,000,000 ам.долларын хөрөнгийг буцаан төлөх шаардлагатай болсон.
3. ICTG token (АйСиТи Групп ХК): Монголын ICTG token нь виртуал хөрөнгө ба үнэт цаасны аль алины шинж чанарыг агуулдаг ч Санхүүгийн зохицуулах хорооноос ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.
4. BitConnect: BitConnect платформ нь өндөр өгөөжтэй хүү амласан бөгөөд Понзи схемд үндэслэсэн байсан. 2017 онд платформ хаагдсанаар олон хөрөнгө оруулагчид хохирсон. SEC нь БитКоннектийн үүсгэн байгуулагчдыг залилангийн хэргээр шалгаж, буруутгасан.

ДҮГНЭЛТ

Токенжуулсан үнэт цаасны хөгжлийг блокчэйн технологи болон крипто токенүүдээр хэрэгжүүлж, энэ нь үнэт цаасны зах зээлийн салшгүй хэсэг болж байна. Үнэт цаасыг токенжуулах нь хөрөнгийн өмчлөх эрхийг крипто токен болгон хувиргах үйл явц бөгөөд энэ нь хөрөнгийн эзэмшлийг блокчэйн дээр бүртгэж, төвлөрсөн хадгаламжийн газар зэрэг зуучлагчдын хэрэгцээг арилгахад тусалдаг. Токенжуулсан үнэт цаас нь хэсэгчлэн хуваагдах боломжтой бөгөөд хөрөнгө оруулагчдад хөрөнгийн жижиг хэсгийг худалдаж авах боломжийг олгож, хөрвөх чадварыг сайжруулдаг.

Токенжуулсан үнэт цаас нь 24 цагийн турш арилжаалагдаж, ил тод байдал нь зах зээлд оролцогчдын итгэлийг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулдаг. Ухаалаг гэрээг хэрэгжүүлснээр төлбөр тооцооны хугацааг богиносгож, гүйлгээний зардлыг бууруулдаг. 2030 он гэхэд үнэт цаас болон бусад хөрөнгийг токенжуулах нь уламжлалт гүйлгээний аргуудыг тасалдуулж, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад хүртээмжтэй болгоно гэж үзэж байна.

Улс орнууд токенжуулсан үнэт цаасыг зохицуулахын тулд зохицуулалтын хүрээг тогтоож байна. АНУ-д SEC нь уламжлалт үнэт цаасны хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаарддаг бөгөөд Европын Холбоо MiCA-ийн удирдамж гаргаж, криптогийн зохицуулалтыг стандартчилахаар ажиллаж байна. Азийн зарим улс, тухайлбал Сингапур, Хонконг болон Япон Улс энэ чиглэлд зохицуулалтын орчноо хөгжүүлж байна.

Монгол Улсад одоогоор токенжуулсан үнэт цаасны тухай хууль эрх зүйн орчин бүрдээгүй боловч токен үйлчилгээний систем бий болж, Төлбөрийн системийн журам батлагдсан. Үүнээс авч үзвэл токенжуулсан үнэт цаас санхүүгийн зах зээлд орж ирэх цаг хугацааны асуудал болсныг илтгэж байна.

Судалгаанд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна:

- ⇒ уламжлалт үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд токенжуулсан үнэт цаасыг үнэт цаасны ангилалд хамруулж эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
- ⇒ токенжуулсан үнэт цаасыг сэндбокс зохицуулалтын орчинд турших боломжийг бодлогоор дэмжих, үнэт цаас гаргагчдад таниулах;
- ⇒ олон улсын зохицуулалтын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх, туршлага судлах;
- ⇒ токенжуулсан үнэт цаасны талаар мэдлэгийг хөрөнгө оруулагчдад өгөх;
- ⇒ зохицуулагч байгууллагын албан хаагчдын техникийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх;
- ⇒ токенжуулалтын экосистемийн хэвийн үйл ажиллагааг хангах харилцан ажиллах систем, стандартыг бий болгох.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ U Ledger Insights. “BCG, ADDX estimate asset tokenization to reach \$16 trillion by 2030.” 2022. Available at: <https://www.ledgerinsights.com/bcg-addx-estimate-asset-tokenization-to-reach-16-trillion-by-2030/>
- ◆ Medium. “Asset tokenization: a market estimated at \$68,000 billion by 2030” 2024. Available at: <https://medium.com/realtplatform/asset-tokenization-a-market-estimated-at-68-000-billion-by-2030-d02d2275d194>
- ◆ Монгол Улсын хууль. “Үнэт цаасны зах зээлийн тухай.” 2013. Эх үүсвэр: <https://legalinfo.mn/mn>
- ◆ Government bonds. “Government Sustainable Bond Programme” Available at: <https://www.hkgb.gov.hk/en/greenbond/greenbondintroduction.html>
- ◆ NYALA. “Raise more funds and increase your distribution power with digital assets” Available at: <https://www.nyala.de/en/>
- ◆ Board of Governors. “Tokenized Assets on Public Blockchains: How Transparent is the Blockchain?” 2024. Available at: <https://www.federalreserve.gov/econres/notes/feds-notes/tokenized-assets-on-public-blockchains-how-transparent-is-the-blockchain-20240403.html>
- ◆ Business Research. “TOKENIZED SECURITIES MARKET REPORT OVERVIEW” 2024. Available at: <https://www.businessresearchinsights.com/market-reports/tokenized-securities-market-103933>
- ◆ SEC Official Website: <https://www.sec.gov/>
- ◆ FINRA Official Website: <https://www.finra.org/>
- ◆ CFTC Official Website: <https://www.cftc.gov/>
- ◆ ESMA Official Website: <https://www.esma.europa.eu/>
- ◆ FRC Official Website: <https://frc.mn>
- ◆ MSE Official Website: <https://mse.mn/mn/aboutus>
- ◆ Securities and Exchange Commission “Securities act of 1933” Available at: <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-1884/pdf/COMPS-1884.pdf>
- ◆ U.S. Supreme Court. “Certiorari to the circuit court of appeals” 1946. Available at: <https://supreme.justia.com/cases/federal/us/328/293/>
- ◆ National archives. “Code of Federal Regulations” 2024. Available at: <https://www.ecfr.gov/current/title-17/chapter-II/part-230/subject-group-ECFR68d879261fb42fb>
- ◆ Legal nodes “The EU Markets in Crypto-Assets (MiCA) Regulation Explained” 2024. Available at: <https://legalnodes.com/article/mica-regulation-explained>
- ◆ European Banking Authority Official Website: <https://www.eba.europa.eu/homepage>
- ◆ European Commission “Implementing and delegated acts – MiFID II” 2014. Available at: https://finance.ec.europa.eu/regulation-and-supervision/financial-services-legislation/implementing-and-delegated-acts/markets-financial-instruments-directive-ii_en
- ◆ The European Union. “Regulation (EU) 2023/1114 of the European parliament and of the Council of 31 may 2023” Available at: <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32023R1114>
- ◆ The European Union. “Directive (EU) 2015/2366 of the European Parliament and of the Council of 25 November 2015 on payment services in the internal market” Available at: <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32015L2366>
- ◆ Practical law. “Market abuse” Available at: <https://uk.practicallaw.thomsonreuters.com/Glossary/UKPracticalLaw/I3f4a4589e8db11e398db8b09b4f043e0?transitionType=Default&contextData=%28sc.Default%29>
- ◆ MAS Official Website: <https://www.mas.gov.sg/>
- ◆ Singapore Statutes Online. “Securities and Futures Act 2001” Available at: <https://sso.agc.gov.sg/Act/SFA2001>
- ◆ Singapore Exchange Official Website: <https://www.sgx.com/>
- ◆ SFC Official Website: <https://www.sfc.hk/en/>
- ◆ HKMA Official Website: <https://www.hkma.gov.hk/eng/>
- ◆ Securities and Futures Ordinance. Available at: <https://www.elegislation.gov.hk/hk/cap571!en.pdf>
- ◆ Санхүүгийн зохицуулах хороо. “Санхүүгийн салбарын тойм” 2024. Available at: <https://www.frc.mn/resources/Images/Document/202408/ODbc6/Urult-toim-2024.II-2024.08.16-last.pdf>
- ◆ Арилжаа эрхлэгчдийн холбоо. “Биржийн бус зах зээлийн тойм” Available at: <http://admin.masd.mn/storage/books/BBZZ%20toim%201.pdf>
- ◆ Trade.mn. “ICT security token” Available at: <https://www.trade.mn/asset/ICTG/>
- ◆ Азийн хөгжлийн банкны хүрээлэн “Блокчейн ба токенжигдсон үнэт цаас: Ногоон санхүүжилт татах боломж” судалгаанд: <https://www.adb.org/sites/default/files/publication/566271/adbi-wp1079.pdf>



НОГООН ЗЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

“Ногоон зээл” бол байгаль орчинд ээлтэй, эрчим хүч, ус, дулаан хэмнэх эсвэл хүлэмжийн хийг бууруулах зориулалттай төслийг санхүүжүүлэх, байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зориулагдсан тусгай нөхцөлтэй зээл юм.



Жишээ нь та **“Ногоон зээл”**-ийг дараах **байгальд ээлтэй** хөрөнгө оруулалтад ашиглах боломжтой:

- Байшингаа дулаалж дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй халаагуур худалдан авах;
- Нарны хавтан эсхүл салхин сэнс зэрэг сэргээгдэх эрчих хүчний эх үүсвэр худалдан авах;
- Цахилгаан тээврийн хэрэгсэл, унадаг дугуй худалдан авах;
- Ногоон барилга, амины орон сууц барих, худалдан авах гэх мэт.



--- Яагаад ногоон зээлийг сонгох хэрэгтэй вэ? ---



Хүүгийн хөнгөлөлт: Зарим банк, санхүүгийн байгууллага ногоон зээлд энгийн зээлээс бага хүү санал болгодог.

Өсөн нэмэгдэх өгөөж: та байгаль орчинд ээлтэй хэрэглээг сонгосноор эрчим хүч, ус, түлшний хэрэглээг бууруулан, хэмнэлт хийх боломжтой, мөн байгальд ээлтэй хөрөнгийн үнэ цэнэ улам бүр өсөж байна.

Ирээдүйдээ хөрөнгө оруулна. Та байгальд ээлтэй сонголт хийснээр өөрийн болон ирээдүй үеийн амьдрах орчныг сайжруулж, эх дэлхийгээ хамгаалж буй юм.



Дэлхийн хэмжээнд хийгдсэн ногоон төсөл, зээлийн үр дүнд жил бүр **1 тэрбум тонн** нүүрстөрөгчийн давхар исэл **CO₂** буурч байна (эх сурвалж: Дэлхийн эрчим хүчний хөрөнгө оруулалтын тайлан 2023). Энэ нь **200 сая ширхэг машин 1 жил яваагүйтэй**, дэлхийн хүн бүр таван мод тарьсантай ижил юм.

Дэлхийн банкны мэдээллээр **ногоон зээлийн тусламжтайгаар санхүүжүүлсэн барилга**, үйлдвэрүүд дунджаар **эрчим хүчний хэрэглээгээ 20–30% бууруулсан** (эх сурвалж: Ногоон барилгын үр дүнгийн тайлан 2022, Дэлхийн банк)



Олон улсын судалгаагаар 2023 онд дэлхий даяар **250 сая өрх** нарны хавтан ашиглаж эхэлсэн. **Нарны хавтанг суурилуулсан нэг айл жилд дунджаар 1,200 кг CO₂ хэмнэдэг**. Энэ нь **Азитивийн 10 гаруй том хотыг бүтэн жил утаагүй** байлгасантай тэнцэх юм.

(Эх сурвалж: Сэргээгдэх эрчих хүчний хүчин чадлын статистик 2023, Олон улсын Сэргээгдэх эрчим хүчний агентлаг, болон Нарны хавтангийн хэмнэлт тайлан 2023, Олон улсын эрчим хүчний агентлаг)

Ногоон зээл авахдаа юуг анхаарах вэ?

- ✓ Ногоон зээлийг зориулалтаас өөр зүйлд зарцуулалгүй, төлбөрөө цаг тухайд нь төлөөрэй.
- ✓ Ногоон төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой бичиг баримтаа хадгалаарай (үнийн санал, суурилуулалтын гэрэл зураг, эрчим хүчний хэмнэлтийн тайлан гэх мэт).
- ✓ Банк, санхүүгийн байгууллага ногоон төсөл, ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг тань шалгаж, “ногоон” үр дүн гарч буйг баталгаажуулах хэрэгцээ гардаг тул идэвхтэй хамтран ажиллаарай.
- ✓ Ногоон зээлд хамрагдсанаар гарч буй эерэг өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлтийн туршлагаа бусадтайгаа хуваалцан, эерэг нөлөөлөл үзүүлээрэй.
- ✓ Ногоон зээл нь зээл биш, таны гэр бүл, нийгэм, ирээдүйдээ хийж буй урт хугацааны хөрөнгө оруулалт юм шүү.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

OPENAI 40 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ ТАТАХААР ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.



Токио — OpenAI компани SoftBank-р тэргүүлсэн хөрөнгө оруулагчдаас 40 тэрбум ам.долларын санхүүжилт татахаар хэлэлцэж байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь хиймэл оюун ухааны судалгаа, хөгжүүлэлтийг эрчимжүүлэх зорилготой. SoftBank-аас гадна томоохон технологийн компаниуд ч уг хэлэлцээнд оролцож байна.

Энэ нь OpenAI-ийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинэ загварууд хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлэх юм.

Эх сурвалж: www.reuters.com

АНУ MEDICARE ADVANTAGE ХӨТӨЛБӨРИЙН НӨХӨН ТӨЛБӨРИЙГ 2026 ОНД НЭМЭГДҮҮЛНЭ.



АНУ-ын Засгийн газар 2026 онд Medicare Advantage хөтөлбөрт хувийн даатгалын компаниудад олгох нөхөн төлбөрийг дунджаар 5.06 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэжээ. Энэ нь өмнөх оны 2.2 хувиас хоёр дахин их өсөлт юм.

Тус шийдвэр зарлагдсаны дараа хувьцааны үнэ UnitedHealth 6.0 хувь, Humana 12.3 хувь, CVS Health 6.6 хувиар мэдэгдэхүйц өсөж, даатгалын компаниудад эергээр нөлөөлж байна. Шинжээчид энэ өсөлтийг Трампын засаг захиргааны Medicare Advantage хөтөлбөрийг дэмжиж буй дохио хэмээн үзэж байна.

CMS-ээс мэдээлснээр, энэхүү нэмэгдэл нь эмчилгээний зардал өсөж буйтай холбоотой бөгөөд иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой юм.

Эх сурвалж: www.reuters.com

ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ АЗИ БОЛОН ЕВРОПТ.



2025.04.14 — Ази тив, Хонг Конгийн Hang Seng индекс 2.4 хувиар, Hang Seng Tech индекс 2 хувиас дээш өсжээ.

БНХАУ-ын дотоодын зах зээл дээр Шанхайгийн нийлмэл индекс 0.76 хувь, Шэньжэний бүрэлдэхүүн индекс 0.51 хувиар өсөв.

Японы Токио хотод, Nikkei 225 индекс 1.18 хувь, өргөн хүрээтэй Topix индекс бараг 0.9 хувиар өслөө.

Бусад бүсүүдэд, Өмнөд Солонгосын KOSPI индекс 0.95

хувь, Австралийн S&P/ASX 200 индекс 1.34 хувиар өссөн бол Тайванийн Taieх индекс 0.08 хувиар буурсан байна.

Технологийн хувьцаанууд онцгой сайн үзүүлэлттэй байлаа. Японы Tokyo Electron компанийн хувьцаа 2 хувиар өссөн бол туршилтын төхөөрөмж үйлдвэрлэгч Advantest 5.4 хувийн өсөлт үзүүлжээ. Мөн Өмнөд Солонгосын Samsung Electronics 1.4 хувиар өссөн байна.

Европын зах зээлд, STOXX 600 индекс 1.8 хувиар өсөв. Германы DAX индекс 2 хувиас дээш өсөлттэй бол Францын CAC 40 индекс 1.9 хувь, Их Британийн FTSE 100 индекс 1.95 хувиар нэмэгджээ.

Эх сурвалж: www.abcnews.go.com

ГАНА УЛС ГАДААДЫН ИРГЭДИЙГ АЛТНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОХЫГ ХОРИГЛОЛОО.



2025.04.14 — Гана улсын Засгийн газар 2025 оны 01–р сарын 30–ны өдрөөс өмнө дотоодын алтны худалдаанд оролцож буй гадаадын иргэдийг гаргах шийдвэр гаргалаа. Энэ нь алтны салбарыг шинэчлэн зохицуулах зорилготой Ганын Алтны Зөвлөлийн тухай хууль (Act 1140)–ийн хүрээнд хэрэгжиж байна.

Шинэ журмаар Алтны Зөвлөл (GoldBod) нь жижиг уурхайдаас алт худалдан авах, борлуулах, турших, экспортлох эрхтэй цорын ганц байгууллага бөгөөд гадаадын иргэд зөвхөн тус байгууллагаар дамжуулан үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Энэхүү шийдвэр нь алтны хууль бус наймааг зогсоож, улсын орлогыг нэмэгдүүлэх зорилготой. 2024 онд Гана улсын алтны экспорт 52.6 хувиар өсөж, 11.6 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Эх сурвалж: www.reuters.com



ТРАМП IRS–ИЙН КРИПТОВАЛЮТЫН “БРОКЕР” ДҮРМИЙГ ЦУЦАЛЛАА.

АНУ–ын Ерөнхийлөгч Дональд Трамп төвлөрсөн бус криптовалютын биржүүдийг (DeFi) “брокер” гэж үзэх татварын шинэчлэлтийг цуцалсан хуульд гарын үсэг зурлаа. Байдены засгийн үед батлагдсан уг дүрмээр DeFi платформууд нь хэрэглэгчийн мэдээлэл илгээх үүрэг хүлээсэн байв.

Крипто салбарынхан уг дүрмийг “биелшгүй” гэж шүүмжилж, Конгрессийн зүгээс ч олонхын саналаар цуцалсан. Трамп өөрийгөө “крипто ерөнхийлөгч” хэмээн тодорхойлж, криптовалютын хөгжлийг дэмжих бодлого баримталж байна.

Эх сурвалж: www.reuters.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

S&P 500 /[^]GSPC/

5,158.20 -124.50 (-2.36%)



Nikkei 225 /[^]N225/

34,220.60 -59.32 (-0.17%)



FTSE 100 /[^]FTSE/

8,287.22 +11.29 (+0.14%)



NASDAQ Composite ([^]IXIC)

15,870.90 -415.55 (-2.55%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

ШУДАРГА ЕС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/

АВАГИА
ХИНА СУЛТАН
АНХР СОМРОЛЫН ЗОРИОЛ

АВИАТАЙН ТӨМӨРХ ГАЗАР